



МОНГОЛ-ЯПОНЫ ТӨВИЙН ЯПОН ДАХЬ ДАДЛАГА СУРГАЛТЫН ТАЙЛАН

2024.10.20-11.02

Улаанбаатар хот
2024 он

ГАРЧИГ

1. Сургалтын талаарх товч танилцуулга
2. Бизнесийн үндсэн сургалтын төгсөгч
 - 1) Г.АМАРЖИЛ
 - 2) Г.АРИУНТӨГС
 - 3) М.БАТБАЯР
 - 4) Б.БАЯНДАЛАЙ
 - 5) Б.БАЯРМАА
 - 6) Б.БОЛОРЦЭЦЭГ
 - 7) О.ДАВААНЯМ
 - 8) Б.ДЭЛГЭРЭХ
 - 9) А.ГАНБАТ
 - 10) Б.НАРАНГАРАВ
 - 11) Ц.ПҮРЭВЖАРГАЛ
 - 12) Г.ТӨРТОГТОХ
 - 13) Д.ТҮВШИНЖАРГАЛ
 - 14) Д.ӨЛЗИЙХАНД
 - 15) Д.УРАНГОО
3. Загвар аж ахуйн нэгж компани
 - 16) Д.БОЛД-ЭРДЭНЭ
 - 17) Э.ОНОН
 - 18) Ц.ЦЭНГЭЛБАЯР
4. Үндэсний сургагч багш
 - 19) Д.ДОЛГОРМАА
 - 20) Б.УГТАХЖАРГАЛ
5. Монгол-Японы хүний нөөцийн хөгжлийн төвийн мэргэжилтэн
 - 21) О.БАЯРМАА
 - 22) Х.ЖАРГАЛМАА

Япон дахь дадлага сургалтын талаарх товч танилцуулга

Бизнесийн хүний нөөцийг хөгжүүлэх үйл ажиллагааны хүрээнд 2002 оноос эхлэн Бизнесийн үндсэн сургалтыг 22 дахь жилдээ зохион байгуулж байна. Тус сургалтад 2024 оныг хүртэл давхардсан тоогоор нийт 1100 гаруй жижиг дунд аж ахуй нэгжийн удирдлага болон менежерүүд суралцаж төгссөн.

Бизнес сургалтын төгсөгчдийн туршлагаас харахад сургалтаар сурсан зүйлээ бодитоор хэрэгжүүлэхээр хичээл зүтгэл гарган ажиллаж байгаа боловч, төдийлөн үр дүнд хүрч чадахгүй байх нь олонтой учир Япон маягийн менежментийн хэрэгжүүлэлтийг Японы компаниудын бодит байдлыг харж, сонсож суралцах нь илүү үр дүнтэй хэмээн энэхүү дадлага сургалтыг санаачлан зохион байгуулж эхэлсэн билээ. Бизнес эрхлэгчдэд Япон компаниудын бодит байдалтай биечлэн танилцаж, бид ямар түвшинг зорих ёстой вэ гэдэг загвар жишгийг нүдээр харж мэдрэн, туршлагаас нь суралцсанаар компаниудын үр ашигтай зохион байгуулалт шийдвэр гаргалтад нөлөөлж, улмаар энэ нь бизнес сургалтын үр дүн жинхэнэ утгаар хэрэгжиж, Монголын жижиг дунд бизнес цэцэглэн хөгжихөд дорвитой хувь нэмэр болно гэж үзэж байгаа юм.

Энэхүү сургалтаар дамжуулан олж авсан мэдлэг туршлагаа үр дүнтэй ашиглах талаар ажлын төлөвлөгөөг заавал боловсруулах бөгөөд сургалтын дараа ажлын төлөвлөгөөгөө бусадтай хуваалцах зорилгоор энэхүү тайланг бэлтгэн дараа дараагийн суралцагчдадаа танилцуулж байна.

Энэ удаагийн сургалт дараах агуулгаар явагдаж дууслаа.

1) Сургалтын талаарх товч танилцуулга

Сургалтын нэр: Бизнесийн үндсэн сургалт төгсөгчид болон
Үндэсний сургагч багш нарын Япон дахь дадлага сургалт

Сургалтын хугацаа: 2024.10.20 (Ням) - 11.02 (Бямба) 2 долоо хоног

Сургалтын зорилго, агуулга:

Япон маягийн менежментийг ойлгох, өөрийн компанийн бизнесийг сайжруулах, хөгжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааны төлөвлөгөөг авч үзэх.

- Өөрийн компанийн менежментийн асуудлаа тодорхойлох
- Японы компанид бодитоор айлчлан удирдах албан тушаалтантай санал бодлоо солилцож, бизнесийн сургалтаас сурч мэдсэн Япон маягийн менежментийн талаарх ойлголтоо гүнзгийрүүлэх.
- Бизнесийн сургалт болон Япон дахь дадлага сургалтаас олж авсан мэдлэгээ өөрийн компанийн бизнесийн сайжруулалт, хөгжүүлэлтэд үр дүнтэй ашиглахын тулд үйл ажиллагааны төлөвлөгөөг гаргах
- Япон төвийн оролцогч тал (ажилтнууд гэх мэт) ямар хүний нөөцийг хөгжүүлэх хүсэлтэй байна вэ гэх мэт, Япон дахь дадлага сургалтаар олж авсан мэдлэг дээрээ тулгуурлан Япон төвийн ажилтнуудад хувь нэмэр оруулж, Япон төв дахь бизнесийн сургалтын менежментэд үр дүнтэй ашиглах.

Нэр: Г. Амаржил

Үндсэн сургалтад хамрагдсан он: 2022 он

Анги: Удирдлагын анги



Ажиллаж буй байгууллагын нэр	AYA CORSET BELT ХХК
Албан тушаал	Гүйцэтгэх захирал
Байгуулагдсан он	2022 он
Үйл ажиллагааны чиглэл	Хувцас эдлэл оёдол Дотоод болон гадаад худалдаа
Нийт ажилтны тоо	20

Компанийн товч танилцуулга

1998 оноос эхлэн хүний нуруу бөөрөнд зориулж эрүүл мэнд гоо сайхны корсет даруулган бүсний анхны загварыг бүтээсэн.

2013 Эрүүл мэнд гоо сайхны даруулган бүсний салон байгуулагдав.

2018 онд “Аяа корсет даруулган бүс”-ний анхны нэрийн дэлгүүр

2021 онд онлайн худалдаа, ОУ-ын захиалга нийлүүлэх боломж бүрдэв.

2024 он ӨМӨЗО орны нийслэл Хөх хотод салбар нээх, онлайн сүлжээнд дэлгүүр нээх ажлын судалгааны ажил эхлэв.

Аяа корсет белт ХХК нь хүний эрүүл мэнд, гоо сайханд нөлөө үзүүлэх, бөөр нуруу, биеийн галбир засахад зориулагдсан бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг бөгөөд 85% эмэгтэйчүүд, 15% эрчүүд хэрэглэж байна.

Аяа даруулган бүсийг нуруу, бөөр өвддөг хүмүүс болон жингийн илүүдэлтэй хүмүүс жингээ хасах зорилгоор, хүүхэд төрүүлсэн эмэгтэйчүүд гэдэс агшаах, тамирчид нурууг хамгаалах зорилгоор хэрэглэж байна.

1. Япон дахь дадлага сургалтад хамрагдах зорилго

Япон хүний бизнес эрхлэх мэдлэг чадвараас суралцах,

Удирдлага болж ажиллаж буй миний хувьд Япон улсаас сайн сайхан зүйл сурч мэдэж өсөж хөгжөөд компаниа хөгжүүлж тэлэхэд хэрэглэх

Компанийн өсөлт дэвшилтэд хэрэгцээт арга барилыг түлхүү мэдэж ирэх

2. Суралцсан зүйл

- 5S

-Тогтвортой хөгжлийн бодлого

- Эмх цэгц, дэг журам, бодит биелэлтийг авчрах сургалтын системүүдийг мэдэж авав.

- Шийтгэлийг бус хамтдаа хөгжиж дэвшихийг урьтал болгох ёстой компаниудын ажилтнаа хайрлах гэсэн бодлогуудын үр дүнтэй танилцаж суралцав.

- Сэтгэл зүрх шингэсэн чанартай бүтээгдэхүүнийг бүтээхийн тулд ямар олон шат дамжлаг хариуцлагыг тооцох зөв системийг мөрдөж ажилласнаар хэрэглэгчдэд хэрхэн хүрдэг тухай бодитоор танилцаж мэдэж ойлгов.

- Үндэсний үйлдвэрлэгч компанийн хувьд зөв алсын хараа зорилго зорилтууд тавьж ажилласнаар улс орны хөгжилд хэрхэн нөлөөлдөг ба улс орондоо эргээд бодит хөгжлийг авчрах хүч нь болдог тухай

- Удирдагч хүний цөхөршгүй үнэнч байдал түүний урам зориг бадрангуй хүсэл мөрөөдөлдөө тууштай байсан нь ямар олон хүмүүст ажиллаж амьдрах суралцах боломжийг өгдөг тухай суралцав.

3. Сургалтаар суралцсан, байгууллагадаа хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө

- Компани өөрийн гэсэн философитой болж, ажилчид болон хэрэглэгчдэд таниулах ажлыг өрнүүлэх

- Үйлдвэрийн багт 5S хөтөлбөрт сургалтыг оруулж, одоо байгаа байдлыг илүү эмх цэгц, дэг журамтай болгох

- Борлуулалтын багт үйлчилгээний стандартын сургалтыг авснаар хэрэглэгчдэд илүү их тав тухыг мэдрүүлэх

4. Цаашид хэрэгжүүлэхийг хүсэж буй үйл ажиллагааны агуулга (Компани болон хувь хүний хувьд)

- Компанийн засаглалын хувьд илүү төгөлдөржүүлэх ажлыг өрнүүлэх

- Байгууллагын менежментийн ажлыг хариуцдаг менежерүүдийн багийг хөгжүүлэх

- Үйл ажиллагаанд 5S хөтөлбөрийг хэрэгжүүлж, илүү эмх цэгцтэй, үлгэр жишээ компани болж хувирах

- Гадаад худалдааны чиглэлд шинэ, оновчтой төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжилтэд хяналт тавьснаар компанийн ашиг орлогыг нэмэгдүүлэх

- Хувь хүний хөгжлөөс байгууллагын хөгжил. Олон улсын хүн болгож хөгжүүлэх тал дээр анхаарах ёстойг гүн гүн гүнзгий ойлгосон. Тиймээс хэлний мэдлэг, хуулийн боловсрол, компанийг хэрхэн амжилттай удирдах ёстой талаар мэдлэгжих ажилд өөрийгөө дайчилна.

- Үүсгэн байгуулагчаас хэрхэн амжилттай CEO болгож өөрийгөө өөрчлөн хөгжүүлэх тал дээр сургалтуудад сууж өөртөө анхаарна.

5. Дараа дараагийн сургалтад хамрагдах хүмүүст зориулсан зөвлөгөө, анхааруулах зүйл

- Цаг баримтлах

- Хоёр улсын хамтын томоохон хөтөлбөр тул хувь хүний зүгээс ёс суртахууны өндөр түвшинд биеэ зөв авч явах тал дээр хичээх

- Энэ хөтөлбөрт оролцож буй нь удирдагч хүний хувьд өөрийнхөө бизнесийг олон талаар харах чадвартай болгох томоохон хөтөлбөр бүхий цогц сургалт юм хэмээн ухамсарлаж, Японд өнгөрүүлэх өдөр бүрээс тэмдэглэл хөтөлж, идэвхтэй хандах

Нэр: Г.Ариунтөгс

Үндсэн сургалтад хамрагдсан он: 2022 он

Анги: Удирдлагын анги



Ажиллаж буй байгууллагын нэр	Тулга төхөөрөмж ХХК
Албан тушаал	Гүйцэтгэх захирал
Байгуулагдсан он	2005 он
Үйл ажиллагааны чиглэл	Мэргэжлийн гал тогооны тоног төхөөрөмж худалдаа
Нийт ажилтны тоо	45

Компанийн товч танилцуулга

“Тулга төхөөрөмж” ХХК нь 2005 онд байгуулагдан 15 жилийн турш худалдаа, нийтийн хоолны тоног төхөөрөмж, хүнс, хоол үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгслийн худалдаа, ган хийц болон тоног төхөөрөмжийн үйлдвэрлэл тэдгээрийн угсралт, суурилуулалт, засвар үйлчилгээг хийхийн сацуу хөргөх, хөлдөөх камерийн угсралт, засвар, үйлчилгээ чиглэлээр үйл ажиллагааг өнөөдрийг хүртэл тогтвортой явуулж байгаа мэргэжлийн байгууллага юм.

Манай компани нь олон улсын чанарын стандартад нийцсэн дэвшилтэд технологид суурилсан тоног төхөөрөмжүүдийг өөрийн улсын зах зээл дээр нэвтрүүлэн, үйл ажиллагааныхаа цар хүрээг өргөжүүлэн тэлж салбартаа тэргүүлэгч инженеринг компани байх эрхэм зорилгыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

ХУДАЛДАА, ҮЙЛЧИЛГЭЭ

Бид 2019 онд өөрийн 1000м² талбай, 4 давхар бүхий нийтийн хоол, ресторан, бар, зочид буудал болон хангамжийн чиглэлийн нийт 10,000 гаруй нэр төрлийн бараа бүтээгдэхүүний сонголттой төвлөрсөн цогц дэлгүүрийг нээж ажиллаж байна.

ҮЙЛДВЭРЛЭЛ

Манай байгууллага 2013 онд Солонгос улсаас сүүлийн үеийн технологиор коструль, зэвэрдэггүй ган сав суулганы үйлдвэр нэвтрүүлэн дээж бүтээгдэхүүнүүдээ зах зээлд гарган борлуулж байна. Мөн зарим нэг голлох тоног төхөөрөмжүүд болон гал тогооны тавилга, 1,2,4 ширэмтэй шарах шүүгээтэй цахилгаан пийшин, төрөл бүрийн хэмжээтэй бэлтгэлийн ган ширээ, шаталсан тавиур, ажлын ширээ, ханын тавиур, тос баригч, 2-р хоолны тогоо зэргийг ОХУ-ийн ГОСТ стандартыг хангасан сэлбэг, эд анги ашиглан хэрэглэгчдийн хүсэл сонирхолд нийцүүлэн чанарын өндөр түвшинд үйлдвэрлэж байна.

1. Суралцсан зүйл

QUOTE TO REMEMBER

2024

ЮУ Ч БОЛСОН ЭЕЛДЭГ НАЙРСАГ БАЙДАЛ НЭН ТЭРГҮҮНД.

САЙХАН СЭТГЭЛЭЭР АЖЛАА ХИЙХ ЮМ БОЛ САЙН БҮТЭЭГДЭХҮҮН ӨРГӨН БАРЬЖ ХЭРЭГЛЭГЧИЙН СЭТГЭЛ ХАНАМЖИЙГ БИЙ БОЛГОНО.

KEY OBSERVATIONS

01

TOTO's Inclusive Workplace Design

NORMALIZATION

TOTO нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулсан ажлын байраа нямбай зохион байгуулж, тэргэнцэр, оюуны бэрхшээлтэй хүмүүст зориулсан

02

YASKAWA

PRODUCTIVITY

Робот-хүний хамтын ажиллагааны энэхүү загвар нь ажилчдад аюулгүй, утга учиртай үүрэг гүйцэтгэхийн зэрэгцээ бүтээмжийг нэмэгдүүлэх технологийн боломжийг харуулж байна.

03

SKYFLYER- SERVICE

DIFFERENTIATION

Ялгаралын давуу тал болон байрлалын давуу талуудыг ашиглан өрсөлдөөнт зах зээлд бусдаас ялгарах өвөрмөц онцлог, хэрэглэгчийг сонсох ач холбогдол

04

NAKASHIMA TURRET

5S-PERFECT LEVEL

5S арга нь стандартыг тогтоогоод зогсохгүй ажлын байр эмх цэгц, аюулгүй, зохион байгуулалттай ажлын байранд ажиллах ажилчдын эрхийг дэмждэг.

05

GOTO KENTO

FOLLOW-UP

Танилцсан мэдээлэлүүдийг эргэн бататгасан Өргөн хүрээний ОУ болон ойрын жишээг татан хэлэлцүүлэг хийж байгаа нь илүү сэтгэгдэл төрүүлж, зорилгийг бататгаж, хэрэгжүүлэхэд дөхөм болсон.

2. Сургалтаар суралцсан, байгууллагадаа хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө



2024

СУРЧ, АЖИГЛАСАН ЗҮЙЛС:

- SDG Awareness in Japan vs. Mongolia
- Human-Centered Company Philosophy
- The 5S Methodology хэрхэн үр дүнтэй тогвортой хэрэгжиж байгаа

ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗҮЙЛС:

1. **ТХЗ-ын талаарх мэдлэгийг дээшлүүлэх**
Зорилго: Дэлхий дахины өрсөлдөх чадварт тогтвортой хөгжлийн гүйцэтгэх үүргийг ойлгодог ТХЗ-ыг эрхэмлэдэг бизнесийн нийгэмлэгийг дэмжих.

2. **Human-Centered Company Philosophy-awareness**
Зорилго: Ажилчдын сайн сайхан байдал нь бизнесийн загвартай салшгүй холбоотой ажлын байр бий болгож, бүтээмж, өс суртахууныг дээшлүүлнэ.


3. **5S аргачлалыг хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулах**
Зорилго: Ажлын байрны үр ашиг, аюулгүй байдал, цэвэр байдлыг сайжруулж, чанар, хариуцлагын соёлыг төлөвшүүлнэ.

ХУГАЦАА
2025 Q4

Нэр: М.Батбаяр

Үндсэн сургалтад хамрагдсан он: 2023 он

Анги: Удирдлагын анги



Ажиллаж буй байгууллагын нэр	“Делакс” тавилгын үйлдвэр
Албан тушаал	Чанар, аюулгүй ажиллагаа хариуцсан захирал
Байгуулагдсан он	2005 он
Үйл ажиллагааны чиглэл	Тавилга үйлдвэрлэл, худалдаа
Нийт ажилтны тоо	42

Компанийн товч танилцуулга

ЭРХЭМ ЗОРИЛГО:

Монгол хүний чадамжаар хил хязгаарыг давж, өнгөрснөөс ирээдүйг холбосон өнөөдрийг сайжруулан бүтээж, итгэл төгс хөгжинө

АЛСЫН ХАРАА:

Дэлхийд өрсөлдөх Монгол ур ухаан

2004 оноос үүсгэн байгуулагдах үндэс сууриа тавьж 2005 оноос импортын тавилга худалдаа, 2014 оноос гэр ахуй, оффисын тавилгын үйлдвэрлэл, худалдаа чиглэлээр үйл ажиллагаагаа тасралтгүй явуулж байна.

Бид 2022 онд олон улсын чанарын удирдлагын тогтолцоо ISO 9001:2015, хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын ISO 45001:2008 стандартуудын шаардлагыг хангаж баталгаажсан бөгөөд салбарынхаа чиглүүлэгч байгууллага болсон. Бид үйл ажиллагаандаа ямагт хэрэглэгчийн эрх ашгийг эрхэмлэн чанараар тэргүүлэн дэлхийн түвшинд өрсөлдөхөөр зорин ажиллаж байна.

1. Япон дахь дадлага сургалтад хамрагдах зорилго

- Хүний нөөцийн асуудлыг хэрхэн шийдвэрлэж байгаа
- Хэрхэн бага хүчээр ихийг бүтээж амжилттай ажиллах
- Маркетинг хэрхэн хийх
- Менежерүүдийн хандлагыг өөрчлөн нэг зүгт зорих хүсэл тэмүүлэлтэй болгох
- Хөдөлмөр хөнгөвчлөх аргууд
- Автоматжуулалт гэх мэт маш их зүйлийг сурч чадах хэмжээ, ойлгож чадах

түвшнээрээ ойлгож мэдэхийг хүсэж байна.

- Сурсан мэдсэнээ үйл ажиллагаандаа нэвтрүүлж, Монголын түүхийг шинээр бичиж олон олон салбарынханд үлгэр дуурайлал болмоор байна.

2. Суралцсан зүйл

- Бид байгууллагынхаа философид гүн итгэж дурлах хэрэгтэй
- Бид тогтвортойгоор зорилгодоо хүрсэн тоглогч байхын тулд өөрсдөө суралцахаа зогсоож болохгүй
- Бид ажилчиддаа өөрсдөө үлгэрлэх ёстой, тэдэнд биш эхлээд өөрсдөдөө тэр шаардлагаа тавих хэрэгтэй
- Бид чанарыг ямар ч үед доголдуулж болохгүй
- Бид 5S-ийг яасан ч тасалдуулж болохгүй
- Бид шинэ эринд нийгмийн хариуцлага хүлээх ёстой
- Бид залуу үеийн дуу хоолойг сонсохын тулд тэдэнд боломж олгож аажуухнаар сэтгэл зүрхийг нь сонсох хэрэгтэй
- Би иноваци, технолгийн дэвшилд хийх хөрөнгө оруулалтыг авч үзэх хэрэгтэй
- Бид байгалд ээлтэй шийдлийг олох хэрэгтэй
- Бид ажлыг хугацаатай төлөвлөн гүйцэтгэж, хугацаандаа тайлагнаж, түүнийгээ хугацаандаа дүгнэж, хугацаанд нь сайжруулдаг байх хэрэгтэй PDCA
- Бид зөвхөн нүдэнд харагддаг зардлыг биш харагддаггүй зардлууд дээр эхлээд анхаарал хандуулах хэрэгтэй (Ажлын цаг, сул явалт гэх мэт)

3. Сургалтаар суралцсан, байгууллагадаа хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө

- Цэвэрлэгээний журам батлуулна
- Ажилтан бүр зочдод байгууллагаа танилцуулах чадамж, мэдлэг олгох сургалт, гарын авлагыг боловсруулна
- 5S ягштал баримтлах тушаал батлуулна
- Байгууллагын философийг ажилчдад илүү түгээх, ойлгуулахын тулд хурал, ярилцлага зэрэгт ярилцдаг ойлголтоо бататгадаг арга барилыг нэвтрүүлнэ
- Тусгай хэрэгцээт иргэдийг ажиллуулах нөхцөл боломжийг судалж, шаардлагатай төсвийг 2025 оны төсөвт суулгуулна
- Шинэ санаачилга гаргаж чадахгүй байгаа ажилтан тусламжийн карт бөглөж бусдаас тусламж аван В үнэлгээ, тусалсан ажилтан А үнэлгээ авдаг аргачлал талархлын үнэлгээнд нэмүүлж батлуулна.

- Аливаа шинэ болон өөрчлөлтийг Z үеийнхэнтэй тусгайлан уулзаж санал бодлыг нь сонсдог арга барилыг уламжлал болгоно.
- Чанарын шалгалтыг тухайн ажилтан бүртэй ярилцаж сайжруулснаар B үнэлгээг хасна.
- Байгууллагын холбогдолтой жижиг бэлэг дурсгалын зүйлсийг зочдод худалдаалах боломжийг үүдний хэсэгт бүрдүүлнэ.
- Автоматжуулалт хийх боломжуудыг судалж, бүх нөөц боломж, өгөөжийг нь танилцуулж ажиллана.
- Сэргээгдэх эрчим хүч буюу нарны хавтангаар цахилгааны зарим хэрэглээх зохицуулах боломжийг судалж танилцуулна.
- Өөрчлөгдөн буй бизнес загваруудыг судлах, сургалтад олон хүмүүсийг хамруулах талаар тушаал гаргуулах.

4. Цаашид хэрэгжүүлэхийг хүсэж буй үйл ажиллагааны агуулга (Компани болон хувь хүний хувьд)

Япон улсад очих миний мөрөөдөл гайхалтайгаар биелж энэ хорвоо ертөнцийн гайхамшгаас өчүүхэн ч гэсэн харсан даа маш их баяртай байна. Японд явахдаа Монгол хүн гэдэг нэрийг, багийнхан дундаа “Делакс” гэдэг нэрийг өргөж явахыг хүсэж, ойлгосон сурсан бүхэн минь энэ л компанитай минь шууд холбоотой гэж бат итгэсээр явсан. Над шиг бодолтой дүү нар маань ч зүгээ л олохгүй цуг хөгжиж дэвшихийг хүсэж байгаа. Тэднийг бид одоо л чиглүүлээд өгчихвөл 2 дахин хурдан гүйчих гээд байна гэж итгэж байна. Харсан, үзсэн, ойлгосноо аль болох тэдэнд төсөөлүүлэх. Очоод харчих юмсан, үзчих юмсан гэсэн хүслийг нь өдөөх. Тэр хүсэл тэмүүлэл дээр үндэслээд дэмжих.

Миний тээж ирсэн мөрөөдөл бол 1-ээрээ биш 2-оороо биш 3-аараа ч биш өшөө олуулаа дараагийн 20 жилд 50 жилийн амжилтыг бүтээх залуучуудаа Япон оронтой танилцах аялалд явуулах. Магадгүй бид ирэх жил 20 жилийн ой гэж найр наадам хийж байснаас 5-10 сайхан залуучуудаа дундаасаа зардлаа гаргаж байгаад ч хамаагүй аялуулж, нүдийг нээгээд өгвөл буцаад өгөөжөө өгөх хөрөнгө оруулалт байх болов уу.

Мянга сонсохоор нэг үз.

5. Дараа дараагийн сургалтад хамрагдах хүмүүст зориулсан зөвлөгөө, анхааруулах зүйл

- Хэрэв энэхүү тайланг минь сонирхон уншиж байгаа над шиг өөрчлөлт хийхийг хүсэгч байх аваас зөвхөн том гайхалтай зүйлсийг гэлтгүй өчүүхэн жижиг зүйлсийг ч анхаарч хараарай. Гайхалтай суралцах зүйлс чинь Япон оронд маш их байгаа. Жижигхэн хүнс, уух зүйлсийн хаяг, уулзварт дөхөж буй машин гээд анзаарвал маш их суралцах зүйлс байгаа.
- Үүнийг уншигч та өөрөөсөө би өөрчлөгдөхөд бэлэн үү гэж эхлээд асуугаарай. Хэрэв тийм бол танд амжилт хүсье. Эхлээд өөрөө өөрчлөгдөж байж өрөөлийг өөрчилнө шүү.

Нэр: **Б.Баяндалай**Үндсэн сургалтад хамрагдсан он: **2023 он**Анги: **Менежерийн анги**

Ажиллаж буй байгууллагын нэр	Смарт И Ар Пи Про Экспертс ХХК
Албан тушаал	Гүйцэтгэх захирал
Байгуулагдсан он	2023 он
Үйл ажиллагааны чиглэл	<ul style="list-style-type: none">Программ хангамжийн үйлчилгээБизнесийн зөвлөгөө өгөх
Нийт ажилтны тоо	10

Компанийн товч танилцуулга

Смарт Софтвэйр групп нь дотоодын зах зээлд ERP системийг 2014 оноос хойш хөгжүүлэн нийлүүлэн ирсэн. Манай компани нь 2023 оноос группийн нэг охин компани болон тусдаа үйл ажиллагаа явуулж байна. Бид бизнесийн байгууллагад тохирсон ERP системийг нэвтрүүлэх, зөвлөх, сургалт зэрэг үйл ажиллагааг явуулдаг одоогоор 3,000 гаруй харилцагчдад нэвтрүүлэлт үйлчилгээний чиглэлээр үйлчилгээ үзүүлж байна.

Эрхэм зорилго: Бид харилцагчдынхаа бизнес мөрөөдлийг биелүүлэхэд тусална.

Уриа: Ухаалаг бай, Түрүүлж алхана

1. Япон дахь дадлага сургалтад хамрагдах зорилго

- Менежерийн ангид сурсан зүйлсээ илүү бодитоор харж, сурах
- Япон маягийн менежмент гэж юу вэ гэдгийг судлах, сурах
- Үйлчилгээний төгөлдөршилд гэж юу гэдгийг судлах, сурах

2. Суралцсан зүйл

- Хүний эрхийн гинжин хэлхээ ба бизнес хийхэд хүний эрхийг чухалчлан авч үзэх
- Үүсгэн байгуулагчийн философийг бүх ажилтандаа ойлгуулах, алсын хараа эрхэм зорилгыг хүн бүр мэддэг мэдэрдэг тэнд хүрэхийн тулд тэмүүлдэг байх.

- Юм бүтээх нь хүн бүтээхээс эхэлнэ. Ажилтан албан хаагчдаа тасралтгүй сургах
- Нийгэм ба ирээдүйдээ хөрөнгө оруулалт хийх
- Ажилчдаас гарсан санаа санаачилгыг үргэлж дэмжсэнээр ажлын бүтээмж өсөх ажилчдын урам зориг ажилдаа хандах хандлага нэмэгдэж байна.
- Кайзэн, 5S-ийн ач холбогдол эмх цэгц хуучирдаггүй гэдгийг ойлгосон
- Япон маягийн менежмент бол хүн төвтэй байх гэдгийг ойлгож авсан
- Хүний нөөцийн хомсдолыг хөгжлийн бэрхшээлтэй иргэдээр нөхөж болох ба автоматжуулалт хийх

3. Сургалтаар суралцсан, байгууллагадаа хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө

- 7 хоног бүр үүсгэн байгуулагчийн топ мессеж ажилчдаа хүргэх, сарын болон өдрийн зорилго зорилтыг ойлгуулах хэрэгжүүлэх
- Мэргэжлийн ур чадварын тэмцээн зохион байгуулах
- Угтах үдэх соёлыг нэвтрүүлэх
- Үйлчилгээний чанарын стандартыг нэвтрүүлэх түүнийг дагасан хяналтын системийг би болгох
- Хэцүү харилцагчтай харилцах тусгай мэргэжлийн баг би болгох
- Хүн өөрийгөө өөрчилдөг түүнд нь туслах, идэвхтэй дасгал хөдөлгөөн хийх

4. Цаашид хэрэгжүүлэхийг хүсэж буй үйл ажиллагааны агуулга (Компани болон хувь хүний хувьд)

- Харилцагч хариуцсан менежерийг япон монголын менежерийн ангийн сургалтад суулгах хөгжүүлэх
- Казейн, 5S –ийн сургалт авч хэрэгжүүлэх
- Хяналтын тогтолцоог илүү нарийн болгох сайжруулах
- Боломжит ажлын байр болон ажил дээр хэсэгчилсэн автоматжуулалтыг нэвтрүүлэх
- Компани болон бүтээгдэхүүний түүхээр музей хийх
- Ажилтны дотоод болон гадаад сургалтыг сар бүр төлөвлөөгд оруулж тогтмол хийдэг болох

5. Дараа дараагийн сургалтад хамрагдах хүмүүст зориулсан зөвлөгөө, анхааруулах зүйл

- Өөрийн компани дээр тулгамдаж буй асуудлаа нарийн тодорхойлох, очиж буй компаниа сайн судлах түүнээс тулгамдаж буй асуудалтай холбоотой сайжруулж болох асуултуудыг бэлдэж явах
- Япон компани ихэвчлэн нээлттэй нийтлэг зүйлсээ танилцуулах ба гол амжилтын нууц, түүнд хүрсэн арга замаа ярихгүй тул тэр талаас нь асууж судлах
- Ухаалаг утасны note ашиглан зураг авч гол санаануудаа байнга тэмдэглэх энэ нь тайлан тавих болон дараа нь компани дээрээ хэрэгжүүлэх үед хэрэг болно.

Нэр: **Б.Баярмаа**

Үндсэн сургалтад хамрагдсан он: **2019 он**

Анги: **Удирдлагын анги**



Ажиллаж буй байгууллагын нэр	Мастер фүүдс ХХК
Албан тушаал	Үйлдвэрийн дарга
Байгуулагдсан он	2019
Үйл ажиллагааны чиглэл	Катеринг, түргэн болон нийтийн хоолны сүлжээ, бэлдцийн үйлдвэр
Нийт ажилтны тоо	450+

Компанийн товч танилцуулга

Манай компани нь 1998 оноос Монголын анхдагч нийтийн хоолны Берлин Бургер сүлжээг үүсгэн үйл ажиллагаагаа эхэлсэн бөгөөд одоогоор Мастер Фүүдс нь катеринг хоол, цэвэрлэгээ үйлчилгээ, түргэн болон нийтийн хоолны сүлжээ, бэлдцийн үйлдвэрлэл эрхэлж байна.


КОМПАНИЙ БҮТЭЦ

100% ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧ


MAX GROUP

MASTER FOODS

КОМПАНИ ТҮҮХЭН ХӨГЖИЛ



BRANDING



Харилцагч байгууллагууд

150+

Бусад үйлчилгээ

- Катеринг-4
- Hotels-2
- Office-



SKU 500+



ISO 9001-2015

1. Япон дахь дадлага сургалтад хамрагдах зорилго

1. Компани болон үйлдвэрийнхээ үйл ажиллагааг сайжруулах Японы компаниудын менежментийн туршлагаас суралцах
2. Компанийн засаглалыг сайжруулах, сайн туршлагаас суралцах
3. 5S тогтолцоог хэрхэн үр дүнтэй нэвтрүүлж буй сайн туршлагаас суралцах

2. Суралцсан зүйл

1. Хүний эрхийн мэдлэгтэй, нийгмийн хариуцлагатай компани, ажилтнаас эхлээд бага ч гэсэн оролцоотой байх нь ирээдүйдээ хийж буй хөрөнгө оруулалт болж байгааг харсан. Үүнийг өөрийн ажиллаж буй компанийнхаа үйл ажиллагааны стратегид тусган ажиллана гэж төлөвлөж байна.
2. Алсын хараа, эрхэм зорилго болон менежментийн зорилго зорилтоо хуваалцах нь ажилтан болон удирдлага нэгдсэн нэг зорилго зорилттой байх, нэг зүг рүү хамтдаа харж алхах боломжийг нээдэг юм байна. Зөвхөн энэ нь удирдлагын хийдэг зүйл биш хамтаараа ажилтнуудын хамтын оролцоотойгоор хүрдэг юм гэдгийг дадлага сургалтад хамрагдаж байхдаа сурсан. Сургалтын хөтөлбөрөө илүү оновчтой болгон гэж харсан.
3. 5S болон Кайзэн амжилттай нэвтрүүлсэн компаниудаар зочилсон нь өөрийн хариуцаж буй үйлдвэртээ хэрэгжүүлж болох маш олон санаа, мэдлэгийг олж мэдсэн. Иймд газар дээр нь зочилж мэдсэн зүйлээ цаашид өөрийн үйлдвэртээ хэрэгжүүлэхээр зорьж ажиллаж байна.
4. Thank you карт- энэ компанийн удирдлагын хувьд хэрэгжүүлж эхэлснээ ажилтын түвшинд бие биедээ талархах боломжийг илүү нэмэгдүүлэн гэж төлөвлөж байна.
5. Хүний нөөцийн дутагдалтай энэ цаг үед робот хүний ажиллагааны сайн хослуулан хэрэгжүүлж буйг хэд хэдэн компанид харснаа өөрийн үйлдвэрлэл, үйлчилгээний салбарын автоматжуулалтын төлөвлөгөөндөө тусган илүү судлан хэрэгжүүлэн гэж төлөвлөж байна.

3. Сургалтаар суралцсан, байгууллагадаа хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө

1. 2025 ондоо OGSM-дээ нийгмийн хариуцлагын хүрээнд бүтээгдэхүүний хувьд илүү аюулгүй органик байдлыг эрхэмлэх, хогны менежментийг хэрэгжүүлэхээр тусган батлагдсан байгаа, хэрэгжүүлэлтээ илүү оновчтой байхаар багаараа хамтран төлөвлөгөө гаргахаар ажиллаж байна. Мөн дараа дараагийн жилүүдэд илүү ирээдүй рүүгээ харсан олон стратеги баримталж ажиллана гэж зорьж байна.
2. Үйлдвэрлэлийн үйл ажиллагаа явуулдаг учраас зайлшгүй 5S хэрэгжүүлэх шаардлагатай гэдгийг сургалтад оролцож байхдаа ойлгосон. Энэ нь аюулгүй

байдал, тав тух болон бүтээмж үр ашигтай байдал чухал нөлөө үзүүлэх бөгөөд 2025 ондоо нэвтрүүлэхээр төлөвлөж байна. Эхний ээлжид нийт ажилтнууддаа 5S-ийн мэдлэг мэдээлэл өгөх шаардлагатай бөгөөд энэ талаар анхан шатны сургалтыг зохион байгуулсан. Оны эцсийн үндсэн хөрөнгийн тооллогоос эхлэн эмхэлж цэгцлэх ажиллагааг хийж гүйцэтгэн өөрчлөлтийн ялгааг нийт ажилчдадаа таниулах, түүнийг хэрэгжилтийн үр нөлөөг илүү ойлгуулан хариуцсан нэвтрүүлэх баг томилон ажиллахаар төлөвлөж байна. Үүний дараа ажилтнуудаасаа Кайзэн санал авах ажиллагааг хийж эхэлнэ.

3. Thank you карт - тус компанийн удирдлагын хувьд хэрэгжүүлж эхэлснээ ажилтын түвшинд бие биедээ талархах боломжийг илүү нэмэгдүүлэхээр ажилчдын хоол идэх хэсэгт талархал хайрцаг, картыг байршуулан хэрэгжүүлэн эхэлсэн.
4. Дэвшилтэт технологи бүхий автоматжуулалтын судалгааны ажил 2025 ондоо илүү нарийвчлан судлан үйл ажиллагаандаа нэвтрүүлэн гэж зорьж байна.

4. Цаашид хэрэгжүүлэхийг хүсэж буй үйл ажиллагааны агуулга (Компани болон хувь хүний хувьд)

Компанийн хувьд: Япон компаниуд нь нийгмийн хариуцлагаа ухамсарласан байдал болон жижиг гэлтгүй бодитой үр дүнд чиглэсэн арга хэмжээ авч ажилладаг нь харагдсан. Иймд цаашид нийгмийн хариуцлагаа ухамсарлаж байгаль орчинд ээлтэй бодлого төлөвлөгөө хэрэгжүүлэхээр компанийнхаа жил бүрийн бизнес төлөвлөгөөний OGSM-д тусган хувь нэмрээ оруулахаар төлөвлөж байна.

Хувь хүний хувьд: Тасралтгүй сайжруулалт хийж нь надаас эхлэх бөгөөд өөр дээрээ аливаа өөрчлөлтийг бий болгон, түүнийг удирдаж буй багтаа мэдлэгээ түгээх нөлөөллийг илүү нэмэгдүүлэн гэж харж байна.

5. Дараа дараагийн сургалтад хамрагдах хүмүүст зориулсан зөвлөгөө, анхааруулах зүйл

Япон дахь сургалтын хэрэгцээ шаардлагаа зөв тодорхойлох хэрэгтэй. Мэдлэгээ бататгах асуултаа асуух, өөрийн мэдлэгээ тухай бүр тэмдэглэл хөтлөн, хэрэгжүүлэх зүйлсээ маш тодорхой бэлтгээд түүндээ хүрэх цаг хугацааг тодорхой төлөвлөх юм бол энэхүү япон дахь дадлага сургалтын үр дүн гарна. Мэдээж богино хугацаанд энэхүү сургалтын үр дүн бол гарахгүй боловч тасралтгүй тууштай хэрэгжүүлэх юм бол урт хугацаандаа танай байгууллагын үйл ажиллагаанд сайн үр дүнг авчрах юм.

Нэр:

Б.Болорцэцэг

Үндсэн сургалтад хамрагдсан он: 2023.09 сар – 2023.12 сар

Анги:

Менежерийн анги



Ажиллаж буй байгууллагын нэр	Монголын Алт (МАК) ХХК
Албан тушаал	Барилгын материалын чанарын менежер
Байгуулагдсан он	1993 он
Үйл ажиллагааны чиглэл	<ul style="list-style-type: none"> - Уул уурхай- түүхий эд олборлолт, борлуулалт, ашиглалт - Барилгын материал үйлдвэрлэл - Аялал жуулчлал, үл хөдлөх - Хөдөө аж ахуй - Бусад дэмжин ажиллах охин компаниуд
Нийт ажилтны тоо	4,000 гаруй
Компанийн товч танилцуулга	
<p>Давуу тал (Өрсөлдөгчөөс ялгарах): Өөрийн байр сууриа олсон, эрсдэл даах чадвартай,</p> <ul style="list-style-type: none"> ➢ Бүтээгдэхүүн нүүрс – Хятадын зах зээлд танигдсан ➢ Барилгын материал – Монгол улсын хэмжээнд чанараар танигдсан(түүхий эдийн нөөц өөрийн эзэмшлийн ордтой) - Цаашдын бодлого: Орчин үеийн шилдэг техник, технологи хиймэл оюун ухамсарт тулгуурлан бизнесийг төрөлжүүлэн хөгжүүлэх, хариуцлагатай уул уурхай, барилгын материалын олон улсын стандартад нийцсэн тогтвортой хөгжил ногоон ирээдүйг цогцлоосон чинээлэг дундаж давхаргын Бүтээлч Монголыг бүтээх 	
1. Япон дахь дадлага сургалтад хамрагдах зорилго	
<ul style="list-style-type: none"> - Японы уламжлалт хэв маягийг хэрхэн эвдсэн, шинэлэг менежментээр ажиллаж байгаа компаниас шилжилтийн хэв маягийг суралцах (хэрхэн ямар замаар шилжилт хийсэн, компанийн туршлага) - Хүний нөөцөө хэрхэн тогтоон барьж байгааг судлах (шинэ менежменттэй компаниудаас) - SDG-г хэрхэн хэрэгжүүлж байгааг өөрийн компанитай харьцуулалт хийх (өөрийн ажиллаж буй МАК ХХК-ийг тодорхой хэмжээнд хэрэгжүүлж байгаа гэж боддог) - Бүтээгдэхүүний чанарын менежментийг хэрхэн төгс хэрэгжүүлж хэвшүүлсэн байдал? 	

2. Суралцсан зүйл

- Хүн бүтээх соёл, боловсролын системийн бодлого
- Компанийн философи, соёл ойлгомжтой байх, ажилтан 1 бүр ойлгосон байх нь тухайн компани урт удаан хугацаанд оршин тогтнох үндэс суурь болсон
- Компанийн үйл ажиллагааны үндсэн зорилго нь их хэмжээний ашиг олох бус, улс нийгэмд өөрийн хувь нэмрээ оруулах, нийгэмд тустай үйл хийх (Фүкүяа түрсний үйлдвэрийн философи)
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг ажлын байраар хангах, тэдгээр иргэдийн ажиллах орчин нөхцөлийг гайхалтай бүрдүүлж өгсөн байдал
- Бүтээгдэхүүний чанарын хяналтыг хүн хүчний хүртээмжтэй байдлаар, нягт нямбай хариуцлагатай гүйцэтгэж байгаа нь (Lexus болон Тото)
- Хүн, робот хосолсон үйлдвэрлэл ажлын бүтээмжийг дээшлүүлсэн байдал, мөн роботоор биеийн хүч шаардах хүнд ачаа тээвэрлэх боломжтой
- Тээврийн компанийн боловсон хүчин татах хүлээлт цалин, хариуцлагатай сургалт/2 сарын/, техникийн бүрэн бүтэн байдал аюулгүй ажиллагааг хангаж, мото цагийн үйлчилгээний давтамжийг ойртуулсан
- Китаюшү хотын агаар орчин, хөрс, усны бохирдлын асуудлыг иргэн, компани, улс хамтран шийдвэрлэж чадсан асуудал болон хог хаягдлыг дахин боловсруулах үйлдвэр (*хэдийгээр үйлдвэрийг нь үзээгүй ч, Такамияа байгалийн түүхийн музей-ээс их зүйл ойлгосон*) байгуулж өнөөгийн гайхалтай хотыг бүтээж чадсан байдал
- Сургалтаас өмнө SDG-ийн талаар компанийн нийгмийн хариуцлагын хүрээнд хийгдэж байгаа ажлуудыг андуурч, буруу ойлголттой байснаа мэдэж авсан.
- Удирдагч хүний алдаатай шийдвэр ямар их хор хөнөөл дагуулдаг болох (Нагасаки хотод хаясан атомын бөмбөгийн хор уршиг) Эх дэлхий энх тайван байгаасай.

3. Сургалтаар суралцсан, байгууллагадаа хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө

- Тус сургалтын хүрээнд олж авсан мэдлэг ойлголт, 2 улсын соёлын ялгааны талаар хамт олон, үйлдвэр уурхайн ИТА /инженер техникийн ажилтан/ нарт танилцуулах сургалт хийх
- Компанийн хэмжээнд байгууллагын соёлыг бүрэн ойлгуулах сургалтыг зохион байгуулах саналыг хариуцсан хэсэг нэгжид санал болгох
- Чанар хяналт: үйлдвэрүүдийн чиглэл тус бүрд тохирох саналыг хүргүүлэх, бүтэц орон тоог нэмэгдүүлэх, дамжлагын хяналтыг сайжруулах
- Боловсон хүчин: МАК компанийн хувьд сонирхогч талыг татах нэр хүнд байна, хүлээлтэд хүрэхгүй байгаа талаар танилцуулах сургалтаа тусгаж санал оруулах
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төвтэй хамтран ажиллах, тэдний хөдөлмөрлөх эрхийг дэмжих чиглэлээр компанид санал оруулах

4. Цаашид хэрэгжүүлэхийг хүсэж буй үйл ажиллагааны агуулга (Компани болон хувь хүний хувьд)

Одоогийн Монгол улсад тулгамдаж байгаа, шийдвэрлэх шаардлагатай асуудал бол Улаанбаатар хотын агаар орчны бохирдол, хог хаягдлын асуудал хүнд түвшинд хүрээд байгаа.

Мөн уул уурхайн салбар тэр тусмаа нүүрсний уурхайн баяжуулах үйлдвэрүүдийн хаягдал болон хөрсний овоолгуудыг эзийн засгийн эргэлтэд оруулах боломжийг судлах

5. Дараа дараагийн сургалтад хамрагдах хүмүүст зориулсан зөвлөгөө, анхааруулах зүйл

Тус сургалтаар бид Япон улсын соёл, туулж өнгөрүүлсэн түүхэн замналыг өөр өөрийн өнцгөөс олж харан, харилцан бие биеэсээ суралцаж байсан. Тиймээс дараа дараагийн олон залуус энэ сургалтаар дамжуулан их зүйлийг сурч, улс эх орондоо хийж бүтээн, хэрэгжүүлэх хүсэл эрмэлзэл дүүрэн ирнэ гэдэгт итгэлтэй байна.

Энэ сургалтыг зохион байгуулж бидний оюун мэлмийд мэдлэг нэмэрлэсэн Монгол-Японы төв болон JICA-гийн хамт олон та бүхэндээ гүнээ талархаж байна.

Нэр: О.Давааням

Үндсэн сургалтад хамрагдсан он: 2023 он

Анги: Менежерийн анги



Ажиллаж буй байгууллагын нэр	Байгалийн Чулуун Хийц ХХК
Албан тушаал	Үйл ажиллагаа хариуцсан менежер
Байгуулагдсан он	2012
Үйл ажиллагааны чиглэл	Барилгын засвар засал чимэглэл. Чулуу засах, зүсэх, тэгшлэх үйл ажиллагаа. Мод модон эдлэлийн үйлдвэрлэл, худалдаа.
Нийт ажилтны тоо	53
Компанийн товч танилцуулга	
<p>2012 онд чулуу зүсэх, өнгөлөх, тэгшлэх, угсрах чиглэлээр үүсгэн байгуулагдаж, өдгөө мод, модон эдлэлийн үйлвэрлэл худалдаа, төмөр хийц, будаг гэх мэт үйл ажиллагаагаа тэлсээр байна. Анх 5 хүнтэй эхэлж байсан бол одоогоор 53 ажилтан 5,000м2 үйлдвэрийн байр, 3 загварын байртайгаар үйл ажиллагаагаа явуулаж байгаа салбартаа тэргүүлэгч компани юм.</p>	
1. Япон дахь дадлага сургалтад хамрагдах зорилго	
<p>Үйл ажиллагаагаа сайжруулах, хүний нөөцийн асуудлыг шийдэх арга, япон соёлыг үзэж танилцах.</p>	
2. Суралцсан зүйл	
<p>Хүний эрх, тогтвортой хөгжил /SDG/ Япон соёл Технологийн дэвшил Энх тайван</p>	
3. Сургалтаар суралцсан, байгууллагадаа хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө	
<p>Тусгай хэрэгцээт хүний нөөц бүрдүүлэх талаар судалгаа энэ ондоо багтаан хийж, 2025 оноос эхлэн дотоод сургалтын хөтөлбөр боловсруулан шинэ ажилтан бэлдэх. Энэ ажлаас үүдэн ажлын байрыг тусгай хэрэгцээт хүмүүст зориулан тохижуулах</p>	

ажлыг хийж гүйцэтгэнэ. Жишээ: ажил эхлэх, завсарлах, цайны цаг зэрэгт гэрэл дохио байршуулах, ажлын талбайг өнгөөр ялган, зурвас, тэмдэг тэмдэглэгээг зэрэг зүйлсийг 2025 оны 3-р сар гэхэд дуусгах.

Ажилчдын ажиллах орчныг сайжруулж амралтын өрөө тохижуулах. 2025 оны 6-р сар

4. Цаашид хэрэгжүүлэхийг хүсэж буй үйл ажиллагааны агуулга (Компани болон хувь хүний хувьд)

Ур чадвартай ажилтан бэлдэх зорилгоор сургалт бэлдэн тогтмол сайжруулах

Өөрийн ярих илтгэх чадварыг сайжруулах

5. Дараа дараагийн сургалтад хамрагдах хүмүүст зориулсан зөвлөгөө, анхааруулах зүйл

Баг хамт олноос болон Япон улсаас маш их зүйлийг сурахаас гадна олон найз нөхөдтэй болно.


Тиймээс та явсандаа хэзээ ч харамсахгүй.

Анхааруулахад буруу зүйл асуучих вий гэж санаа зоволтгүй өөртөө итгэлтэйгээр асуумаар, ойлгоогүй зүйлсээ илэн далангүй шууд асуугаарай.

Нэр: Б.Дэлгэрэх

Үндсэн сургалтад хамрагдсан он: 2023 он

Анги: Удирдлагын анги



Ажиллаж буй байгууллагын нэр	Лайфтроник ХХК
Албан тушаал	Бизнес хөгжил хариуцсан дэд захирал
Байгуулагдсан он	2014
Үйл ажиллагааны чиглэл	Эмнэлгийн хэрэгсэл, оношлуур, тоног төхөөрөмж ханган нийлүүлэх
Нийт ажилтны тоо	26

Компанийн товч танилцуулга

Лайфтроник ХХК нь Лабораторийн хөгжлийг Монголд авчрах алсын хараатайгаар шилдэг технологийг нэвтрүүлж, чанарыг эрхэмлэсэн бизнесийг бүтээх эрхэм зорилгыг биелүүлэхээр үйл ажиллагаагаа 2014 оноос хойш явуулж байна.

Бид итгэл даах чадвар, итгэл даасан чанар, итгэлтэй хамтын ажиллагаа, итгэлээр дүүрэн санаачлагч, зөв дадал зуршлыг бизнесийнхээ үнэт зүйл болгон Монгол улсын нийт 341 (орон нутагт - 136, хотод улсын - 48, хувийн - 157) идэвхтэй хэрэглэгч (лабораториуд) нарт дэлхийн 20 гаруй орноос (Франц, АНУ, БНСУ, БНХАУ гэх мэт) лабораторийн тоног төхөөрөмж, хэрэгсэл, урвалж оношлуурыг тусгай зөвшөөрөлтэйгөөр ханган нийлүүлж, хүрж үйлчилж байгаа юм.

Мөн тоног төхөөрөмжийн суурилуулалт; мэргэжлийн (микробиологи, хематологи, биохими, молекул биологи, иммунологи) хэрэглээ зүйн сургалт; техник үйлчилгээ, баталгаат засварыг хийж гүйцэтгэж байна.

1. Япон дахь дадлага сургалтад хамрагдах зорилго

Япон компаниудаас туршлага хуримтлуулах ерөнхий зорилгын доор

- Хүний нөөцийн менежмент
- Ажлын орчин
- Бизнесийн тогтвортой хөгжлийн тухай
- Нөөцийн удирдлага
- Япон маягийн менежмент

2. Суралцсан зүйл

- Компанийн алсын хараа, зорилго хамгийн чухал
- Компанийн алсын хараа, зорилгыг бүх ажилчдадаа ойлгуулж ажиллах нэн чухал
- Өдөр тутмын үйл ажиллагаандаа хүний эрхийг тусгаж ажиллах
- Шинэ ажилтны сургалт, үндсэн ажилтан болгох үйл явцын талаар мэдээлэл
- Ажилтан өөрийн ажлын чанарын хяналтыг хийх үйл явц
- Хөгжлийн бэрхшээлийг “normalize” хийж, хүний нөөцийг өөр түвшинд удирдах
- Робот, хүний хамтын ажиллагаа
- Тууштай, эх оронч сэтгэлгээ
- Зөв сэтгэлгээ, ёс зүйг бага наснаас нь ойлгуулж, бэлдэж байна
- Төгс гэж хэлж болохуйц 5S-н хэрэгжүүлэлт
- Бүх зүйл тодорхой, ойлгомжтой, утга учиртай, энгийн зохион байгуулалт
- Тогтвортой хөгжлийн талаар ойлголт сайн, үйл ажиллагаандаа ямар нэгэн байдлаар шингээх гэж хичээж байсан
- Нэг үйл ажиллагааны чиглэлээр сайн гүнзгийрч ажиллах буюу хийж чаддаг зүйлээ хийх
- Цаг үетэйгээ нийцсэн бүтээгдэхүүн хөгжүүлэлт, шийдвэр гаргалт
- Ялгарах стратегийн амжилттай хэрэгжилт
- Өндөр түвшний чанарын хангалт, хяналт
- Хог хаягдлын менежментээс гадна дахин боловсруулалт өдөр тутмын амьдралын нэг хэсэг болсон
- Компанийн тогтвортой хөгжлийн гол түлхүүр бол ХҮНИЙ ХӨГЖИЛ

3. Сургалтаар суралцсан, байгууллагадаа хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө

- ✓ Дунд шатны менежерүүдээ 5S сургалтад суулгаж, агуулах болон оффистоо нэвтрүүлэх
- ✓ Хүний эрхийн тунхаглалыг хөдөлмөрийн дотоод журамдаа тусгаж, мөрдөж ажиллах
- ✓ Ажилчдын ур чадварыг дээшлүүлэх буюу ХҮНИЙ ХӨГЖИЛ
 - Ёс зүй, сэтгэлийн боловсрол, харилцаа хандлага
 - Дотоод сургалтыг сайжруулах (ур чадвар, эрүүл мэндийн боловсрол)

4. Цаашид хэрэгжүүлэхийг хүсэж буй үйл ажиллагааны агуулга (Компани болон хувь хүний хувьд)

Цаашид:

1. Тогтвортой хөгжил (менежмент) - тогтвортой менежментээр хангаж, хязгаарлагдмал нөөцийг хариуцлагатай, үр өгөөжтэйгөөр ашиглах.

2. Цахим систем - үйл явцын нарийн төвөгтэй байдал, ажлын урсгалыг оновчтой болгож, үр ашигтай ажиллах боломжийг олгохоос гадна тогтвортой бөгөөд бага зардлаар нөөцийг ашиглах.

3. Мэдээллийн сан ба аюулгүй байдал - ажлын процесс, өгөгдлийг хянах боломж буюу захиалга болон бараа бүтээгдэхүүний бүртгэл, ажлын хамрах хүрээг тодорхойлох, дээжийг хуваарилах, боловсруулахад дэмжлэг үзүүлэх, үр дүнгийн мэдээлэл цуглуулах, тайлан гаргах, үнэлэх.

4. Нийлүүлэлтийн сүлжээний (blockchain) удирдлага - бараа материалын сайн менежментээр хангаж бизнесийн эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэх.

5. Дараа дараагийн сургалтад хамрагдах хүмүүст зориулсан зөвлөгөө, анхааруулах зүйл


- Хувийн бэлтгэлээ сайн хангах
- Цаг тухай бүрд нь тэмдэглэл хөтлөх
- Сургалтдаа идэвхтэй оролцох

Амжилт хүсье!

Нэр: А.Ганбат

Үндсэн сургалтад хамрагдсан он: 2022 он

Анги: Удирдлагын анги



Ажиллаж буй байгууллагын нэр	Нойкрафт ХХК
Албан тушаал	Гүйцэтгэх захирал
Байгуулагдсан он	2007
Үйл ажиллагааны чиглэл	Эрчим хүч, инженерчлэл
Нийт ажилтны тоо	70

Компанийн товч танилцуулга

Үйл ажиллагааны агуулга:

Найдвартай цахилгаан эрчим хүчний тасалдалгүй хэрэглээг улс орны чухал байгууллагуудад хүргэдэг. Үүнийгээ мэргэшсэн боловсон хүчин шинэлэг технологиудад судлан гүйцэтгэж байна.

Давуу тал (Өрсөлдөгчөөс ялгарах): Тогтвортой найдвартай үйлчилгээ

Цаашдын бодлого: Дээрх үйлчилгээнд бид сэргээгдэх эрчим хүчний мэдээллийг түгээж хэрэглэгчдэд найдвартай үйлчилгээг нэвтрүүлэх

1. Япон дахь дадлага сургалтад хамрагдах зорилго

- Хамтран ажиллах боломжтой байгууллагуудын тухай мэдээлэл цуглуулах
- Боловсон хүчний дутагдалтай байдал буюу хүний нөөцийн хомсдолыг шийдвэрлэх арга замд суралцах
- Тухайн бүс нутгаас гаргасан бизнес эрхлэгчдийг дэмжих арга хэмжээ

2. Суралцсан зүйл

- Хүний эрхийг хамгаалах тал дээр төрийн бодлого хэрэгжүүлдэг ч ажил олгогчид дарамт учруулахгүйгээр дэмжих бодлого барьж байгаа нь авууштай санагдсан.
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг ажиллуулах боломжийг олж харсан.
- Хяналтын хуудсаар болон явцын үед илрүүлсэн үл тохирлыг сайшаан хүлээн авч байгаа нь таалагдсан.

3. Сургалтаар суралцсан, байгууллагадаа хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө

1. Дунд болон богино хугацааны бизнес төлөвлөгөөгөө өөрчлөх шаардлагатай гэдгийг олж харсан.
2. Хэрэгжүүлэх төслүүд бүрийн аргачлалд хяналтын хуудсыг сайжруулж - шинэ төсөл хийж эхлэх ажлын процесст оруулж өгөх шаардлагатай мөн үүнийг хэрэгжүүлэх боломжтой гэж харж байна.

ХУГАЦАА:

Бизнес төлөвлөгөө - 2025 оны 1-р улирал

Хяналтын хуудас - 2024 оны 12 сар

4. Цаашид хэрэгжүүлэхийг хүсэж буй үйл ажиллагааны агуулга (Компани болон хувь хүний хувьд)

1. Удирдлагын дунд болон түүнээс дээш шатны мэргэжилтнүүдээ үндсэн сургалтад жил бүр 1-с доошгүй ажилтан суулгах
2. 5S-ийг 7 хоног бүр хийж хэвших
3. Хөдөлмөрийн бэрхшээлтэй иргэдийг ажиллуулах боломжийг судлах /ажлын байранд ирж очих зам харгуй гээд нэлээд судлах зүйл байна/
4. Нийгэм болон өөрийгөө хүрээлэн буй хүмүүст өөрийн үзэж харсан зүйлийг танилцуулж мэдээлэл түгээхийг хүсэж байна.

5. Дараа дараагийн сургалтад хамрагдах хүмүүст зориулсан зөвлөгөө, анхааруулах зүйл

Үзсэн үйлдвэр, үйлчилгээний байгууллага бүрээс олж харсан хамгийн авууштай зүйлсийг тэмдэглэж тухайн зүйлийг хэрхэн байгууллагад нэвтрүүлэх тал дээр баг болон ангийн дүгнэлт дээр хэлэлцэх боломжийг эрж хайх хэрэгтэй.

Нэр: **Б.Нарангарав**Үндсэн сургалтад хамрагдсан он: **2023 он**Анги: **Удирдлагын анги**

Ажиллаж буй байгууллагын нэр	Амгаланзаяа ХХК
Албан тушаал	Захирал
Байгуулагдсан он	2017 он
Үйл ажиллагааны чиглэл	Үйлдвэрлэл, худалдаа
Нийт ажилтны тоо	17

Компанийн товч танилцуулга



1. Япон дахь дадлага сургалтад хамрагдах зорилго

1. Дэлхийд чанараараа тэргүүлэгч орны ААН-үүдтэй танилцах, туршлага судлах
2. Ирээдүйд Япон улсад экспорт хийх боломжийг хайх
3. Япон улсын амжилтын нууц болох 5S, Кайзэний хэрэгжилтийг үзэж мэдэх улмаар компани дээрээ хэрэгжүүлэх
4. Ижил мөрөөдөлтэй найз нөхөдтэй болох

2. Суралцсан зүйл

1. Бизнес хийх гэдэг нь ямар их утга учрыг агуулж, хүмүүст ямар их хайрыг түгээж, ажилчид болоод хамтран ажиллагчдадаа ямар их сэтгэл зүрхийг гаргаж ажилладаг болохыг харж нэгийг бодож хоёрыг тунгаалаа.
2. Цагийг юмыг цаг нь дүрмийг харлаа
3. Жижиг гэлтгүй бүх зүйлд ач холбогдол өгч ажиллах нь ямар их үр дүнг гаргадаг вэ гэдгийг харлаа.
4. Эмх цэгц гэдэг тухайн орчныг өөрчлөөд зогсохгүй хүний бодол сэтгэлийг цэгцэлж өгдөг юм байна гэдгийг ойлгосон
5. Бид ямар нэгэн зүйлд өөрийн оролцоотой, тэмцэгч байх ёстой юм байна гэдгийг ойлгосон
6. Аливаа юманд хүлээцтэй хандаж, тунгаан бодож, нухацтай хандах хэрэгтэй гэдгийг
7. Аялалд хамт явсан нөхдийнхөө хүсэл мөрөөдөл, хийж буй зүйлүүдтэй танилцаж тэднээсээ мөн их суралцах, хамтран ажиллах ёстой гэдгийг ойлголоо.

3. Сургалтаар суралцсан, байгууллагадаа хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө

1. Манай компани нь яг одоо ISO 9001:2015 хэрэгжүүлж байгаа бөгөөд бид хараахан аудитаа хийлгэж гэрчилгээгээ аваагүй байгаа. Тиймээс бид энэ оны 12 сараас ажилчиддаа 5S сургалтыг явуулж системтэй мэдлэгийг өгч 2025 оны 01 сараас хэрэгжүүлж эхэлнэ.
2. 2024 ондоо компаний философи, алсын хараа, эрхэм зорилгоо харж шинэчилэх
3. 2025 оны хүний нөөцийн төлөвлөгөөндөө Хүний эрхтэй холбоотой заалтуудыг судалж оруулж хэрэгжүүлэх
4. Хүнтэйгээ байнга ажиллах хэрэгтэй гэдгийг маш сайн ойлголоо. Тиймээс ажилчидтайгаа илүү ойр байх, ажлын байрны тав тух, найрсаг харилцаа хандлагийг байгууллагийн соёлдоо шингээх хэрэгтэй гэдгийг ойлгосон учир үүн дээр анхаарч ажиллана.
5. Үйлдвэрлэлийн автоматжуулалт хэрхэн хийгдэж байгааг харсан. Үйлдвэрээ өргөжүүлэн томруулсаны дараа автоматжуулалт хийхэд, роботыг ашиглах зэрэгт анхны мэдэгдэхүүнтэй болсон. Yaskawa робот алибаба дээр зарагддаг гэдгийг мөн олж мэдсэн.
6. Мөн OEM, OBM-ийн талаар бодож үйлдвэрлэлээ хийх хэрэгтэй гэдгийг ирэх жилийн төлөвлөгөөнд оруулж хийнэ.

4. Цаашид хэрэгжүүлэхийг хүсэж буй үйл ажиллагааны агуулга (Компани болон хувь хүний хувьд)

- Компаний философи, компаний соёлыг маш зөв, хүнлэг болгоход аяандаа бизнес дэлгэрэх юм байна гэдгийг ойлгож үүн дээрээ анхаарч ажиллана. Үүнтэйгээ уялдуулан эмх цэгцийг сайн дэлгэрүүлж ажиллах хэрэгтэй гэж харлаа.

5. Дараа дараагийн сургалтад хамрагдах хүмүүст зориулсан зөвлөгөө, анхааруулах зүйл

- ❖ Зорилгоо маш сайн тодорхойлж гаргаад үүнийхээ дагуу фокуслаад явбал илүү үр дүнтэй болов уу. Зорилго тодорхойгүй бол олон тал руу үсчих гээд байдаг талтай харагдсан.
- ❖ Ер нь тэгээд “Зөв явбал зөөлөн зөөлөн замбуулайн” гэсэн бодлыг тээгээд үг, үйлдэл, бодлоо зөв байгаад өөрчлөлтөнд уян хатан, эерэг хандлагатай байхад хэсэгтээ явчих байхаа.

Амжилт хүсье.

Баярлалаа

Нэр: Ц.Пүрэвжаргал
Үндсэн сургалт төгссөн он: 2023
Анги: Удирдлагын анги



Ажиллаж буй байгууллагын нэр	Жак Интернэйшнл ХХК
Албан тушаал	Гүйцэтгэх захирал
Байгуулагдсан он	2016
Үйл ажиллагааны чиглэл	Кофе боловсруулах үйлдвэр, кофешоп
Нийт ажилтны тоо	35
Компанийн товч танилцуулга	
<p>Жак Интернэйшнл ХХК нь 2016 оноос кофе салбарт албан ёсоор үйл ажиллагаа явуулж эхэлсэн дотоодын брэнд юм. Кофе хуурч боловсруулах үйлдвэрийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэхээс гадна кофе шоп ажиллуулдаг. 2024 оны 11 сард анхны франчайз салбараа хөдөө орон нутагт амжилттай нээснээр одоогийн байдлаар 5 салбар кофе шоптойгоор үйл ажиллагаа явуулж байна.</p> <p>Jack's coffee брэндийн эрхэм зорилго нь АЯГА БҮРД АЗ ЖАРГАЛ ТҮГЭЭХ.</p>	
1. Япон дахь дадлага сургалтад хамрагдах зорилго	
<p>Япон маягийн менежментээс суралцах, Япон бизнесүүдийн ажилладаг арга барилтай танилцах, тэдгээрээс суралцах Бизнесээ эмх цэгцтэй удирдан зохион байгуулах</p> <p>Бизнесийн үндсэн сургалтад сурсан зүйлээ компанидаа хэрхэн хэрэгжүүлж байна вэ, компанид гарсан өөрчлөлт</p> <ul style="list-style-type: none">- Стратегийн хичээлээс сурсан зүйлсээ хэрэгжүүлж, байгууллагын roadmap, гол баримтлах чиглэл стратегийг боловсруулан танилцуулсан- Соёл сайжруулах төлөвлөгөө гаргаж, эхлээд хүндээ анхаарах нь чухлыг баримталж эхэлсэн- Дотоод сургалтын агуулгыг сайжруулан дэлгэрүүлж, ойлгомжтой тодорхой болгосон.- Эмх цэгцийг эрхэмлэдэг зан чанарын байгууллагадаа уриалан сурталчилж	

байгаа

- Ажилтнуудаасаа Монгол Японы төвийн үйлдвэрлэлийн болон бизнес шинжилгээ, маркетинг зэрэг сургалтуудад суулгасан.

Дадлага сургалтын зорилго буюу Японоос суралцах зүйлс

- Япон бизнесийн арга барил, зах зээл дээр өрсөлдөх чадвар, менежмент зэрэгтэй нь танилцахыг хүсэж байна.
- Мөн дэлхийн нийлүүлэлтийн гинжин хэлхээний талаарх ойлголтоо тэлэх, япон компаниудын ажилладаг процессын ялгаатай байдалтай танилцах.

2. Суралцсан зүйл

- Бизнесийн салбар амжилттай тогтвортой хөгжихөд нийгмийн систем нөлөөлдөг гэдгийг харлаа. Зөвхөн бизнес эрхлэхээс гадна нийгэмдээ хэрхэн үнэ цэнийг бий болгох вэ гэдгийг харж тусгаж байх нь чухал санагдсан.
- Мөн ажилтны болон хэрэглэгчийн сэтгэл ханамж, бүтээгдэхүүний чанар, процессын сайжруулалт зэрэг дээр тасралтгүй сайжруулалт хийдэг нь онцлууштай байлаа.
- Япон хүмүүсийн зарчимч хариуцлагатай байдал нь онцгой сэтгэгдэл төрүүлсэн. Түүнээс гадна дэлхийн зах зээл дээр япон улсад хувийн компани үүсээд олон зууныг дамжин удаж байгаа нь компанийн соёл хөгжиж явахад чухал нөлөөтэй санагдсан. Компанид 100 жилд юу юу хийж болох вэ гээд бодоход бидэнд нь гэрэлтэй ирээдүй байгаа санагдана. Япон компаниудын нийтлэг нэг ижил зүйл нь байнгын сайжруулалт хийдэг соёл санагдсан. Аливаа ажлыг сайжруулах, бүтээмж нэмэгдүүлэх, хүртээмжтэй ойлгомжтой байлгах дээр анхаарч ажилладаг нь тасралтгүй хөгжиж ирснийх нь нууц гэлтэй.
- Олон нийт болон байгууллага, төрийн оролцоотойгоор нийгмийн асуудлыг хамтарч шийддэг нь бидэнд дутагдаж буй зан чанар байлаа.
- Зочноо хүлээн авах, үдэх соёлоос нь мөн маш их суралцсан.

3. Сургалтаар суралцсан, байгууллагадаа хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө

- Дотоод сургалтыг тогтмол орсноор ажилтнуудын хандлага болон ажлын байран дээр тулгардаг олон ойлгомжгүй зүйлс үгүй болно гэж бодож байна.
- Байгууллагын соёл болон ажлын орчинд онцгой анхаарснаар ажилтнууд тогтвортой сэтгэл хангалуун ажиллах үндэс болох юм байна гэдгийг харлаа.

4. Цаашид хэрэгжүүлэхийг хүсэж буй үйл ажиллагааны агуулга (Компани болон хувь хүний хувьд)

- Ажилтнуудаа ч мөн бизнес аялалд явуулж байх хэрэгтэй гэж санагдсан.
- Бүтээмж бүтээмж бүтээмж. Манай байгууллага бүтээмжийг хэрхэн хэмждэг вэ

гэдгээ харах хэрэгтэй. Ингэснээр бид үр ашгаа дээшлүүлж мөн цалингийн төсвөө ч нэмэгдүүлэх боломжтой байна.

5. Дараа дараагийн сургалтад хамрагдах хүмүүст зориулсан зөвлөгөө, анхааруулах зүйл

- Аль болох notes дээрээ тэмдэглэл хөтлөн зураг текстээ нэг дор хадгалах
- Нэрийн хуудас хангалттай авч явж хүмүүстэй танилцах
- Чөлөөт цагаараа өөрийн сонирхож буй төрлийн үйлчилгээний газруудаар зугаалж амжих
- Сонссон сурсан зүйлсээ эргэн харж амьдралдаа хэрэгжүүлэх.

Сургалтын үр дүн сэтгэгдэл

- Олонтойгоо явахад бие биеэсээ суралцдаг нь сайхан санагдсан. Бага ч болов хугацаанд дэг жаяг, дэглэмд орох нь сонирхолтой байсан. Нөгөө талаасаа илүү хариуцлагын мэдрэмжийг нэмж өгдөг санагдсан. Сургалт миний хувьд маш өгөөжтэй байсан.

Нэр: Г.Төртогтох

Үндсэн сургалтад хамрагдсан он: 2022 он

Анги: Удирдлагын анги



Ажиллаж буй байгууллагын нэр	Зангиа Портал ХХК
Албан тушаал	Дэд захирал
Байгуулагдсан он	2009 он
Үйл ажиллагааны чиглэл	Мэдээлэл технологи
Нийт ажилтны тоо	60

Компанийн товч танилцуулга

Зангиа Портал ХХК нь хүний нөөцийн бүрдүүлэлт, сонгон шалгаруулалт, хувь хүний хөгжлийн чиглэлээр цогц үйлчилгээ үзүүлэн ажилладаг мэдээлэл технологийн үндэсний компани юм.



Хэрэгжүүлж буй төслүүд:
Zangia.mn, Zangia Academy,
Zangia Audio, Zangia Training,
Zangia test, Zangia logon, Zangia

B2B, Zangia survey, HR Monthly Magazine ...

1. Япон дахь дадлага сургалтад хамрагдах зорилго

- Япон орон, Япон соёлтой танилцах
- Японы компани, үйлдвэрлэл, үйлчилгээний байгууллагуудын үйл ажиллагаатай танилцах
- Бизнесийн туршлага судлах, эргээд байгууллагадаа хэрэгжүүлэх

2. Суралцсан зүйл

Зарчмыг хэрэгжүүлж, хэвшүүлэх



Стандарт, дүрэм журмыг маш сайн баримталдаг, энэ нь бүтээгдэхүүн чанартай байхтай шууд хамааралтай байдаг. Дүрэм журмыг хэвшүүлэхэд тууштай байдлаас гадна удирдлагуудын оролцоо тэмүүлэл маш чухал.

Хүний нөөцийг хөгжүүлэх, сэтгэл ханамжтай ажиллуулах

Японы компаниуд хүний нөөцөө хөгжүүлэх тал дээр маш сайн анхаарч ажилладаг санагдсан. Шат шатны сургалтын хөтөлбөр, шинэ ажилтны чиглүүлэх сургалтын хөтөлбөр гэх мэт. Мөн ажилтнуудынхаа санал сэтгэгдлийг сайн сонсож хэрэгжүүлдэг. Байгууллагын үзэл баримтлалаа ажилтнуудынхаа зорилготой нэг байлгахыг зорьдог. Нэгэнт зорилго нэг бол ажилтан бүх сэтгэлээ ажилдаа зориулж улмаар үйлчлүүлэгчийн сэтгэлд хүрсэн бүтээгдэхүүн үйлчилгээ бий болно.



Бүтээмж, автоматжуулалт



Хүний нөөцийн хомсдолын эсрэг шаардлагатай процессыг автоматжуулж байна. Мөн хүн ажиллахад хортой нөхцөл болон хүнд хүчир ажлыг роботоор хийлгэж байна.

AI, robot болон хүн хоорондын ажлын уялдаа холбоог зөв тооцоолж ажлын бүтээмжийг нэмэх боломжтой.

3. Сургалтаар суралцсан, байгууллагадаа хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө

- Тогтвортой хөгжлийн зорилтыг үйл ажиллагаандаа тусгах
- Шаардлагатай зарчим, стандартыг хэрэгжүүлэх, дагаж мөрдөхөд хяналт тавих
- Байгууллагын алсын хараа, эрхэм зорилгоо ажилтан бүрдээ ойлгуулах, ажилтнуудын хүсэл тэмүүллийг анзаарч, санал санаачилгыг үргэлж сонсож

дэмжих

- Бүтээгдэхүүн үйлчилгээгээ тасралтгүй сайжруулж байх

4. Цаашид хэрэгжүүлэхийг хүсэж буй үйл ажиллагааны агуулга (Компани болон хувь хүний хувьд)

Ур чадвараа тогтмол сайжруулах, тууштай байдлыг дадал болгох, стандарт дүрэм журмыг үлгэрлэн манлайлж хэрэгжүүлэх,

Байгууллагынхаа удирдах түвшний ажилтнуудыг энэ дадлага сургалтад хамруулах,

5. Дараа дараагийн сургалтад хамрагдах хүмүүст зориулсан зөвлөгөө, анхааруулах зүйл

- Өөр өөр салбар чиглэлийн байгууллагуудад очдог болохоор өөрийн ажилладаг салбарын байгууллага биш байсан ч бүх зүйлийг нь анхаарч, ажиглаж олон зүйл сурч мэдэх боломжтой.
- Очсон компанийн ажилтнаас асуулт асуух багахан хугацаанд тухайн асуултад хариулах хүн ямар албан тушаалтай, юуг сайн мэдэх вэ гэдгийг бодолцож асуултаа асуувал яг хэрэгтэй мэдээллээ авна.
- Япон чиглүүлэгч багш, зөвлөх багш нартай хичээлийн бус цагаар, автобусанд явж байхдаа олон зүйлийн талаар ярилцах боломж гардаг юм байна лээ, түүнийг ашиглах хэрэгтэй санагдсан.

Нэр: Д.Түвшинжаргал

Үндсэн сургалтад хамрагдсан он: 2022 он

Анги: Удирдлагын анги



Ажиллаж буй байгууллагын нэр	“ХАНЖИНТРАНС” ХХК
Албан тушаал	Гүйцэтгэх захирал
Байгуулагдсан он	2013 он
Үйл ажиллагааны чиглэл	Олон улсын тээвэр зуучлал
Нийт ажилтны тоо	Үндсэн 24, гэрээт 4

Компанийн товч танилцуулга

Давуу тал (Өрсөлдөгчөөс ялгарах):

Манай компани нь дэлхийн 80 гаруй орны 100 гаруй агентийн сүлжээг ажиглан далай, төмөр зам, авто зам, агаарын тээврийг маш хурдан гарц гаргалгаа гарган харилцагчиддаа хүргэдэг давуу талтай эрсдэл даах чадвартай баг хамт олон бий болсон.

Цаашдын бодлого:

Манай улс хэрэглээний барааныхаа 80 орчим хувийг гадаад орноос импортоор худалдан авдаг ба үүнд олон улсаас тээвэрлэх тээвэр ложистикийн үйлчилгээ нь өртөг өндөртэй байдаг. Манай компани нь тээврийн өртгийг хэрхэн яаж эрсдэлгүй бууруулах тал дээр гарц гаргалгаа хайн тууштай ажиллаж байгаа. Тээвэр ложистикийн үйлчилгээг нийгэм, эдийн засагт үр өгөөжтэй болгох хувилбарыг байнга ирэлхийлж технологийн дэвшлийг нэвтрүүлэн ажиллаж эхэлж байгаа.

1. Япон дахь дадлага сургалтад хамрагдах зорилго

- Японы үйлдвэр, үйлчилгээний компаниуд хүний хөдөлмөрийн бүтээмжийг хэрхэн нэмэгдүүлж ажилладаг талаар
- Үйлдвэрлэгч орны үйлдвэрүүд ямар зарчмаар 100 жилийн түүхийг бүтээж байгааг судлан 2 дахь бизнесээ хаягдал дахин боловсруулах жижиг үйлдвэрлэлийн арга барил судлах
- Японы чанар өндөр, үнэ хямд хүнсний бүтээгдэхүүн импортоор оруулж ирэх түүнийг нутагшуулах.

2. Суралцсан зүйл

- Кита Кюүшү хотын хог дахин боловсруулах үйлдвэр хог хаягдлыг дахин боловсруулж хувцас болон бусад хэрэгсэл зэргийг хийж байсан нь энэ төрлийн бизнес хийх боломж байгааг харуулсан.
- Хүний нөөцийн тогтвортой байдал, Компанийн соёлыг таниулах болон ур чадварыг дээшлүүлэх сургалт,
- Хүн рүү чиглэсэн буюу хүнээ хөгжүүлэхийг чухалчилдаг нь Японы компаниудын философийг олж харлаа
- Ажилчдаа тогтмол сургалтад хамруулж, S, A, B, C гэсэн ур чадварын шатлалтай байсан ба сургагч багшийг бэлтгэдэг.
- Тусгай хэрэгцээтэй ажилчдын оролцоог дэмжсэн ажлын орчин бүрдүүлсэн.
- Нийтээрээ 5S болон Кайзэнийг хэрэгжүүлдэг нь Японы компаниудын давуу тал байлаа.
- Ажлын байр, багаж хэрэгслийг эмх цэгцтэй хадгалж, бүтээмжийг нэмэгдүүлэх ажилчид сар бүр зорилго тавьж байлаа.
- Тээврийн компанийн боловсон хүчин татах хүлээлт цалин, хариуцлагатай сургалт/2 сарын/, техникийн бүрэн бүтэн байдал аюулгүй ажиллагааг хангаж, мото цагийн үйлчилгээний давтамжийг ойртуулсан
- SDG-ийн талаар компанийн нийгмийн хариуцлагын хүрээнд хийгдэж байгаа ажлуудыг хэрхэн хийх ойлголттой болж авсан. Япон улсад бизнесийн шинэ санаа, бүтээгдэхүүн хөгжүүлэлт өндөр хөгжсөн байна. Мөн групп компанийн хүрээнд салбар компанийн дэмжлэгтэйгээр үйл ажиллагаагаа саадгүй явуулсан жишээ цөөнгүй байсан

3. Сургалтаар суралцсан, байгууллагадаа хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө

- Компанийн соёлыг таниулах болон ур чадварыг дээшлүүлэх сургалт, идэвхжүүлэлт
- Тусгай хэрэгцээт иргэдийг зайнаас ажиллуулах боломжийг 3 сарын дотор судлах
- Импортыг бүтээгдэхүүнийг судлах, бизнесийн шинэ санаа олох
- Хог хаягдлыг дахин боловсруулалт. Кита Кюүшү хот Eco Town-с санаа авч дахин боловсруулсан
- Мэнтайко үйлдвэрийн бүтээгдэхүүнийг монголд таниулж оруулж ирэх
- Коун траск компанийн ашигладаг шатахууны утаа бууруулагчийг судлах

4. Цаашид хэрэгжүүлэхийг хүсэж буй үйл ажиллагааны агуулга (Компани болон хувь хүний хувьд)

- Монгол улсад маань тулгамдаж байгаа, шийдвэрлэх шаардлагатай асуудал бол Улаанбаатар хотын агаарын бохирдол, хог хаягдлын асуудал хүнд түвшинд хүрээд байгаа.
- Хогоо ангилан ялгадаг болох нь нэн түрүүнд хийгдэх ажил
- Импортыг орлох жижиг дүнд үйлдвэр
- Хог дахин боловсруулах үйлдвэр
- Бүх юмны эхлэл хүн өөрөө. Хүн гэж ямар байх ёстой, бие биеэ хайрлах, хүндлэх болон нийгэмд биеэ авч явах гээд бизнесийн хөгжил, шинэ санаанаас гадна маш их зүйлийг сурлаа.

5. Дараа дараагийн сургалтад хамрагдах хүмүүст зориулсан зөвлөгөө, анхааруулах зүйл

- Бид өөрсдийгөө, Үр хүүхдүүдээ” дэлхийн хэмжээний ухамсарт зөв хүн болгож төлөвшүүлэх ёстойг ойлгуулж өгсөнд баярлалаа.
- Дараа дараагийн олон залуус энэ сургалтаар дамжуулан их зүйлийг сурч, улс эх орондоо хийж бүтээн, хэрэгжүүлэх хүсэл эрмэлзэл дүүрэн ирнэ гэдэгт итгэлтэй байна.

Энэ сургалтыг зохион байгуулсан Монгол-Япон төв болон JICA төвийн хамт олон та бүхэндээ маш их талархаж байна.

*Хүндэтгэсэн;
Д,Түвшинжаргал.*

2024.12.09

Нэр: Д.Өлзийханд

Үндсэн сургалтад хамрагдсан он: 2021 он

Анги: Удирдлагын анги (Онлайн)



Ажиллаж буй байгууллагын нэр	Тайван Хайрхан ХХК
Албан тушаал	Ерөнхий Захирал
Байгуулагдсан он	2010 оны 04 сар
Үйл ажиллагааны чиглэл	Төмөр замын засвар, төмөр бетон дэр үйлдвэрлэл, төмөр зам барих, төмөр замын материалын худалдаа
Нийт ажилтны тоо	15-20 хүн

Компанийн товч танилцуулга

Тайван Хайрхан ХХК нь 2010 онд үүсгэн байгуулагдаад 2011 оноос эхлэн үйлдвэр аж ахуйн газрууд руу салаалан орсон төмөр замыг засварлах тусгай зөвшөөрөл авч 1 байгууллагын төмөр замтай гэрээ хийн ажиллаж эхэлсэн.

Улмаар Говийн их бүтээн байгуулалтад оролцох зорилгоор салбар төмөр зам барих тусгай зөвшөөрлийг 2012 онд авч салбар замыг өргөтгөн шинэчлэх, шинээр төмөр зам барих ажлуудыг хийж эхэлсэн.

Төмөр зам барих, төмөр зам засварлахад зайлшгүй шаардлагатай материал болох дэр мод байдаг. Дэр модыг их хэмжээгээр хэрэглэх нь байгальд болоод байгууллагадаа эдийн засгийн байгалийн сөрөг нөлөөтэй тул төмөр бетон дэрийг үйлдвэрлэх нь чухал гэж үзсэн.

2021 онд төмөр бетон дэр үйлдвэрлэх тусгай зөвшөөрлийг авсан. Үйлдвэрлэл, бүтээгдэхүүн нэвтрүүлэлтийн хэсэг дээр ажиллаж байна.

Төмөр замын засвар үйлчилгээ хийгдэж буй газрууд 2024 оны байдлаар нийт 22 байгууллагатай хамтран ажиллаж байна.

Улаанбаатар хот, Баруунхараа, Хөтөл, Шарын гол, Дархан-Уул аймаг, Сэлэнгэ аймаг хойд бүсийн төмөр зам дагасан газруудад үйл ажиллагаа явуулдаг.

Байгууллага болон үйлдвэр нь Дархан-Уул аймагт оршин байдаг.

1. Япон дахь дадлага сургалтад хамрагдах зорилго

- Япон менежментийг судлах, сурах, байгууллага дээр өөрийн нөөц бололцоог ашиглан хэрэгжүүлэх
- Япон оронтой танилцах, Японы соёл, Япон орныг үзэх
- Хамтран баг болж явах хүмүүстэй танилцах, бизнесийн харилцаа тогтоох

2. Суралцсан зүйл

1. 5S, Кайзэн үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлж байгааг,
2. Хувь хүний соёл, Хүний харилцааны өндөр соёл бол улсын хөгжлийн үндэс юм байна гэдгийг мэдлээ.
3. Байгууллага бүр хүнээ хөгжүүлж, сайн нөөц бэлдэж байж сайн хөдөлмөр бүтээдэг гэдгийг мэдлээ.
4. Байгууллага ажилтныхаа төлөө зүрх сэтгэлээ бүрэн зориулж байгааг харлаа
5. Байгууллага бүр өөрийн философитой, соёлтой, хүний нөөцийн бодлоготой, байгаль орчин, нийгмийн хариуцлагын хүрээнд зохион байгуулдаг ажилтай, чанар стандартыг маш өндөр түвшинд хэрэгжүүлж ажилладаг, хүнээ дээдэлсэн харилцаатай байгаа нь олон жил оршин тогтнохын үндэс юм байна.
6. Сургуулийн наснаас нь цэвэрлэгээг бие даалган хийлгэж байгаа нь сурагч том болоод ажил дээр гарсан ч ажлын байраа цэвэрлэх ёстой гэдэг ухамсарыг суулгасан байгаа нь 5S хэрэгжихэд маш том түлхэц болж байна гэж харж байна.
7. Япон улсад цэвэрлэгч үйлчлэгч гэж тусдаа орон тооны ажилтан байхгүй юм шиг харагдсан ч нийтийн бие засах өрөө маш цэвэрхэн байсан нь хувь хүний соёлтой холбож ойлгож байна. Иймээс өөрийн гэр бүл үр хүүхдээс эхэлж ийм дадал соёлд суралцуулах ёстой гэж ойлгосон.
8. Төлбөр тооцооны хэрэгслүүдийг ашиглаж сурсан гэх мэт олон сайхан зүйл сурлаа.

3. Сургалтаар суралцсан, байгууллагадаа хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө

Хамгийн нэн түрүүнд хэрэгжүүлэх зүйл гэвэл

- Стратеги төлөвлөгөөгөө гаргах
- 5S кайзэн төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх
- Ажлын байрны сургалт зохион байгуулж хэвших
- Өөрийгөө болон ажилтнуудаа чадавхжуулах
- Бүтээгдэхүүн үйлчилгээний чанарыг сайжруулах
- Хөдөлмөрийн аюулгүй ажиллагааг стандартын дагуу явуулж хэвших

4. Цаашид хэрэгжүүлэхийг хүсэж буй үйл ажиллагааны агуулга (Компани болон хувь хүний хувьд)

- МЯТ-с явуулж буй сургалтуудаас боломжит сургалтад тогтмол хамрагдаж байх
- Би өөрөө Япон орноор биеэрээ очиж судалсан хүний хувьд Япон менежментийг байгууллагадаа хэрхэн суулгах, нутагшуулах ажлыг санаачлан эхлүүлнэ.

- Байгууллагадаа 5S-г хэрэгжүүлж цэвэр цэмцгэр, эмх цэгцтэй, ажилтнууд нь сэтгэл зүрхтэй сэтгэл ханамжтай, байгууллагынхаа эрх ашгийг мэддэг, зүтгэдэг тэмүүлэлтэй баг бүрдүүлнэ
- Сайн чанартай баг бүрдүүлж байж ажил урагшилдаг гэдгийг мэдсэн учраас хамгийн түрүүнд хүний нөөцийн бодлогыг зөв хэрэгжүүлэх ёстой юм байна.
- Байгууллагын философи, менежментийг тодорхой болгож хэрэгжүүлэх
-

5. Дараа дараагийн сургалтад хамрагдах хүмүүст зориулсан зөвлөгөө, анхааруулах зүйл

- Хувь хүн бүр соёлтой байгаасай
- Япон орноос суралцах чин хүсэлтэй, сурах зүйлээ тэмдэглэж асууж байх
- Цаг баримтлах
- Хувийн бэлтгэлээ чиглүүлэх сургалтын дагуу бэлдэх
- Бусдад төвөг болохгүй байгаасай.

Нэр: Д.Урангоо

Үндсэн сургалтад хамрагдсан он: 2023 он

Анги: Удирдлагын анги



Ажиллаж буй байгууллагын нэр	“Гоолайф Лорис” ХХК
Албан тушаал	Гүйцэтгэх захирал
Байгуулагдсан он	2022 оны 12сар
Үйл ажиллагааны чиглэл	Хүнс, хоол үйлдвэрлэл
Нийт ажилтны тоо	25

Компанийн товч танилцуулга



“Гоо Лайф Лорис” ХХК нь 2022 онд үйл ажиллагаагаа эхлүүлж, 2023 онд НАССР стандарт нэвтрүүлэн Монголын хүнс үйлдвэрлэлийн салбарт цэвэр, аюулгүй орчинд чанарын өндөр түвшинд, шим тэжээлийн алдагдалгүй боловсруулсан хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэлээр тэргүүлэх түвшинд хүрч ажиллах зорилготойгоор үйл ажиллагаагаа өдөр бүр сайжруулан ажиллаж байна.

Уриа үг: “Амтлаг аз жаргалыг хамтдаа бүтээцгээе”

Үнэт зүйлс:

- Тэргүүн технологи
- Эрүүл бүтээгдэхүүн
- Хариуцлагатай ажилтан
- Итгэлцэл, түншлэл

Эрхэм зорилго:

Технологийн хөгжил, менежментийн бодлогоор, Зөв хүн болон эрүүл хүнсний салбарын инновацологи компани байна.

1. Япон дахь дадлага сургалтад хамрагдах зорилго

Япон маягийн менежментийн талаарх ойлголт болон үндсэн сургалтын онол болон сурч мэдсэнээ бататгаж, практик дээр япон компаниуд хэрхэн компаниа удирдан

зохион байгуулдаг, стандарт зөв хэвшил болон цаашлаад байгууллагын амжилтын нууц нь юун дээр тогтдог зэргийг харж ойлгох.

2. Суралцсан зүйл

- Япон маягийн хүн төвтэй менежментийн талаарх ойлголт
- Хүний нөөцийн удирдлагын арга барил
 - Японд хүнийг чухалчилсан “Хүн төвтэй менежмент” хэрэгжүүлдэг болох нь бүх л компани дээр харагдаж байна. Үүний том жишээ:
 - Компанийн эрхэм зорилгыг мэдрүүлэх, ажилтан ажлаараа дамжуулан нийгэмд ямар хувь нэмэр оруулж буйг ойлгуулах.
 - Ажилчдын сэтгэл ханамж болон Үйлчлүүлэгчийн сэтгэл ханамж тэнцүү гэдэг үзэл.
- 5S болон Кайзэн хэрэгжүүлэхийн ач холбогдол болон хэрэгжилтийн шилдэг жишээнүүд
Маш өргөн хүрээтэй менежмент ба үйлдвэрлэл, үйлчилгээ, оффист ажлын маш өндөр, хурдтайгаар бүтээмжийг нэмэгдүүлж, үргүй олон жилийг хурдтайгаар товчилж болно.

3. Сургалтаар суралцсан, байгууллагадаа хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө

- Мэдээллийн самбар , хаяг , аюулгүй ажил , тоног төхөөрөмжийн зааварчилгаа зурагт самбар шинэчилж сайжруулах
- 5 S хэрэгжүүлэх баг томилох
- Сургалтын төлөвлөгөөнд хүний эрхийн сургалт нэмэх
- Японд сурсан мэдсэн зүйлээ нийт ажилчидтайгаа хуваалцана. Happy hour хийж хоолонд орж, ном уншина
- Ажилчдын амралтын өрөөг тохижуулна


4. Цаашид хэрэгжүүлэхийг хүсэж буй үйл ажиллагааны агуулга (Компани болон хувь хүний хувьд)

- 2025онд “Гоо Лайф Лорис” ХХК 1,500мк2 бүхий төв үйлдвэрийг ашиглалтад оруулах
- 2025-2026онд “Гоо Лайф Лорис” ХХК дэргэдэх ТББ-д нийгмээс гадуурхагдаж буй хүүхэд, эмэгтэйчүүдэд ажлын байр болон сургалт, хөгжлийн замыг нээж өгч нийгэмд гэрлийг түгээж хүний нөөцийн том цогц шийдлийг бий болгоно.
- Борлуулалтын сувгаа тэлж, бүтэгдэхүүний тоог нэмэгдүүлж хэрэглэгчдэд эрүүл бүтэгдэхүүний өргөн сонголтоор үйлчлэх.

5. Дараа дараагийн сургалтад хамрагдах хүмүүст зориулсан зөвлөгөө, анхааруулах зүйл

- Бүх хүний менежментийг өөр дээрээ тусган авч цаад утга санааг ухаж ойлгох
- Суралцах зорилгоо сайтар тодорхойлох
- Суралцах явцад байгууллагаа өөрчлөхийн тулд хувь хүн “Би” хэрхэн өөрчлөгдөхөө тодорхойлох

Нэр: Э.Онон
Хөтөлбөрийн нэр: ЗААН хөтөлбөр
Хөтөлбөрт хамрагдсан он: 2022-2024 он



Ажиллаж буй байгууллагын нэр	“Премиум Палас” ХХК
Албан тушаал	Ресторан хариуцсан захирал
Байгуулагдсан он	2015
Үйл ажиллагааны чиглэл	Зочид буудал, зоогийн газар
Нийт ажилтны тоо	250
Компанийн товч танилцуулга	
<p>Бид Хятад хоолны “ЮуЛонг” сүлжээ ресторан болон Зэн солонгос хоолны ресторан, Зочид буудал, Фитнесс төв зэрэг үйлчилгээгээр зочлох үйлчлэх салбарт 9 дэх жилдээ үйл ажиллагаагаа явуулж байна.</p> <ul style="list-style-type: none">Эрхэм зорилго: Бид Премиум үйлчилгээгээр дамжуулан оролцогч талуудад аз жаргалыг түгээнэ.Алсын хараа: Салбарын хөгжлийг тодорхойлж, үйлчилгээгээр манлайлагч байна.Үнэт зүйлс: <p>Employee: Ажилтан Positive attitude: Эерэг хандлага Quality: Чанар Straightforward: Шударга, ёс зүйтэй, хариуцлагатай байх Teamwork: Багийн ажиллагаа Leadership: Манлайлал Caring: Харилцагч болон ажилтнуудаа халамжлах</p>	

1. Япон дахь дадлага сургалтад хамрагдах зорилго

- Хүний нөөцийн менежментийг сайжруулах зорилгын хүрээнд дараах зүйлүүдэд илүү анхаарч сайжруулалт хийх Үүнд:
 - Компанийн стратегийг илүү тодорхой болгох үүднээс алсын хараа, эрхэм зорилгоо шинэчилж, ажилчдадаа хэрхэн ойлгуулах
 - Дунд шатны удирдах ажилтнуудыг чадваржуулах
 - Ажилтнуудын гүйцэтгэлийн менежментийг хэрхэн сайжруулах талаар илүү суралцаж, үнэлгээний шинэ аргачлалуудыг нэвтрүүлэх
 - Бүтээмжийг нэмэгдүүлэх үүднээс 5S- ийн талаар ойлгох

2. Суралцсан зүйл

- Хүн рүү чиглэсэн буюу хүнээ хөгжүүлэхийг чухалчилдаг нь Японы компаниудын философи байлаа.
- Нийтээрээ 5S болон Кайзэнийг хэрэгжүүлдэг нь Япон компаниудын давуу тал байлаа.
- Хяналт шалгалтыг тогтмол шат дамжлага болгонд хийснээр харилцагчийнхаа итгэлийг хүлээсэн найдвартай түнш болдог Япон соёл. Энэ нь үргүй зардал гаргахаас сэргийлж нөөцөө үр ашигтай зарцуулах боломжийг бүрдүүлж байна.
- Япон улсад бизнесийн шинэ санаа, бүтээгдэхүүн хөгжүүлэлт өндөр хөгжсөн байна. Үүний нэг чухал зүйл нь ажилтан бүр тухайн байгууллагынхаа хөгжил, оршин байхад санаа тавьдагт оршиж байна.
- Хүнээ хөгжүүлэх сургалтын бодлого маш чухал гэдгийг ойлголоо.
- Нөөц үүсгэхгүй зардлаа хэмнэх арга замыг олж харсан.
- Компанийн өсөлт нь хувь хүний өсөлт хөгжилтэй шууд хамааралтай.
- Бүтээгдэхүүн хөгжүүлэлтийг маш сайн хийж байнгын сайжруулалт хийж байх.

3. Сургалтаар суралцсан, байгууллагадаа хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө

- Ажлын байр бүрийн чадамжийг тодорхойлж, сонгон шалгаруулалт, сургалт хөгжил, гүйцэтгэлийн үнэлгээтэй холбох талаар бодлого боловсруулж хэрэгжүүлнэ.
- Ажилчдын чадамж, мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх дотоод сургалтын хөтөлбөрийг боловсронгуй болгож, компани дотроо мэргэжлийн зэргийн тогтолцоо бий болгоно. Үүнтэй уялдуулан шилдэг сургагч ажилчдыг тоог

нэмэгдүүлнэ. Үйлчилгээний ажилчид бие биеэ ажлын байр дээр дадлагажуулан, дасан зохицуулах, сургах бүрэн боломжтой байдаг.

- Хүний нөөцийн тогтвортой байдлыг хангах үүднээс:
 1. Байгууллагын зүгээс нийгмийн халамжийн бодлого, хөтөлбөрийг боловсронгуй болгох.
 2. Тууштай үр бүтээлтэй ажиллаж байгаа ажилчдыг урамшуулах бодлогоо сайжруулах
 3. Ажилтнуудын өөрийгөө хөгжүүлэх сургалтыг дэмжиж, сурч боловсрох, зэрэг дэвээ ахиулах боломж нөхцөлөөр хангах /жич: НБ нар-мэргэшсэн НБ болох, тогооч нар зэргээ ахиулах боломж/
- Үргүй зардлыг бууруулах, бүтээмжийг нэмэгдүүлэх зорилгоор 5S ийн сургалтыг шат дараалалтай авч нийт ажилчдад мөн чанар, утга учрыг ойлгуулж, 2025 оноос хэрэгжүүлж эхлэхээр зорьж байна.


4. Цаашид хэрэгжүүлэхийг хүсэж буй үйл ажиллагааны агуулга (Компани болон хувь хүний хувьд)

- Тусгай хэрэгцээт хүмүүсийг ажлын байраар хангах, хувийн бизнес дээр нь хамтран ажиллах болон тухайн хүмүүсийг өөрсдийн салбар ресторан бусад бусад нэгжүүдэд үйлчлүүлэх нөхцөлийг дэмжихийг хувь хүний хувьд маш их хүсэж байна. Мөн үүнийгээ 2026 он гэхэд дэвшилттэй, шийдэлтэй байхыг зорьж байна.
- Ажлын байр тус бүрээр дасан зохицох хөтөлбөр, сургалт хөгжүүлэлтийн бодлого, албан тушаал ахих шатлал зэргийг боловсруулж хэрэгжүүлэх (Байгууллагын хувьд)
- Шинэ ажилтны гарын авлагын номыг бүрэн мэдээллийн хувьд гарган хэрэгжүүлэх (Байгууллагын хувьд)

5. Дараа дараагийн сургалтад хамрагдах хүмүүст зориулсан зөвлөгөө, анхааруулах зүйл

- Хичээл бүртээ анхаарлаа хандуулан, компани бүрээс 1 зүйлийг зааал сураарай
- Монгол улсад хэрэгжүүлэх боломжтой санаа бүрийг тусгаж аваарай
- Япон хүмүүсийн харилцаа болон соёлоос мөн нэг ч гэсэн зүйлийг өөртөө шингээж аваарай.
- Миний ижил төстэй салбар биш гэж үл тоолгүй байгууллын соёл, эзний болон компанийн философийг мөн суралцаарай.

Нэр: Ц.Цэнгэлбаяр
 Хөтөлбөрийн нэр: ЗААН хөтөлбөр
 Хамрагдсан он: 2023-2024 он



Ажиллаж буй байгууллагын нэр	Кашмер холдинг ХХК
Албан тушаал	Бизнес үйл ажиллагаа хариуцсан менежер
Байгуулагдсан он	2009 он
Үйл ажиллагааны чиглэл	Ноолуур боловсруулж бүтээгдэхүүн үйлдвэрлэх
Нийт ажилтны тоо	1,000 орчим

Компанийн товч танилцуулга

2004 онд Сүлжмэлийн шугамыг тус тус худалдан авч, улмаар нэхмэл сүлжмэл бүтээгдэхүүний гүйцэтгэн боловсруулах иж бүрэн үйлдвэрлэлийг бий болгосноор 2008 онд “Кашмер Холдинг” ХХК-ийг үүсгэн байгуулсан.



“Кашмер Холдинг” ХХК нь дотооддоо өөрийн 6 салбар дэлгүүрээр “ЭВСЭГ” брэндээр бүтээгдэхүүнээ борлуулж байна.

2020 онд бид Өмнөд Солонгос, ОХУ, Англи улсуудад өөрийн нэрийн дэлгүүрээ нээн ажиллаж байна.

Англи, Франц, Итали, Герман, Солонгос, Япон гэх мэт улсуудын нийт 20 гаруй компанитай харилцаа холбоотой ажиллаж, бүтээгдэхүүнээ экспортолж байна.

БАЙГУУЛЛАГЫН ЭРХЭМ ЗОРИЛГО

ЭРХЭМ ЗОРИЛГО

Эх орны үнэт түүхий эд болох Монгол ямааны ноолуур, тэмээний ноосыг бүрэн боловсруулж, техник технологийнхоо түвшинг байнга сайжруулах замаар гадаад, дотоодын зах зээл дээр өсөлдөх чадвартай, нэмүү өртөг бүхий бүтээгдэхүүн үйлдвэрлэж, хамт олныхоо ашиг, орлогыг нэмэгдүүлж эх орныхоо хөгжил дэвшилд хувь нэмэр оруулна.

АЛСЫН ХАРАА

Олон улсын зах зээлд Монголын брэндүүдийг бий болгоход дэмжлэг үзүүлснээр Монголын ноолуурын салбарыг дэлхийд тэргүүлэгч болгоход хувь

УРИА

“Нэг нь нийтийн төлөө, нийт нь нэгний төлөө – Урагшаа, хурай хурай хурай”

ҮНЭТ ЗҮЙЛ

- Ур чадвартай мэргэшсэн ажилтан
- Дэвшилтэт техник-технологи эзэмшсэн
- Компанийн байнгын харилцагч, хэрэглэгч
- Байгальд ээлтэй Эко түүхий эд ноолуур, ноос
- Хэрэглэгчийн сэтгэл ханамж чанартай бүтээгдэхүүн
- Амжилтад хүрэх – Баг, хамтын зүтгэл

ЗОРИЛТ

- Бүтээгдэхүүний чанарыг 99%-д хүргэж баталгаажуулах
- Ажилтан бүр хийсэн ажлынхаа чанарыг шалгадаг, хариуцдаг, үйлдвэрлэл дундын чанар шалгагчгүй болгох
- Бүтээгдэхүүний үл тохирлын хэмжээг бууруулж, дахин хийлтийг 50% багасгах, үр ашгийг нэмэгдүүлэх
- Дотоод гадаад зах зээлд бүтээгдэхүүний чанарыг ижил хэмжээнд байлгах
- Бие биедээ тусалдаг, мэдлэг туршлагаасаа хуваалцдаг байх.
- Хэлтэс алба, нэгжүүдийн Зөрчлийн дугуйланг хэвшүүлж үр дүнд хүргэх

МАНЛАЙЛАЛ



НИЙГМИЙН ХАРИУЦЛАГЫН ХҮРЭЭНД

Ажилчдаа өгөх тусламж	<ul style="list-style-type: none"> Сүүлийн 30-аад жилийн хугацаанд 1,200 гаруй гэр бүлийн гишүүдийн амжиргааг дэмжиж, тэдэнд буцалтгүй тусламж үзүүлсээр ирсэн.
ЖДҮ болон хувиараа хөдөлмөр эрхлэгч дэмжих	<ul style="list-style-type: none"> 40 гаруй жижиг үйлдвэр болон хувиараа хөдөлмөр эрхлэгчдийг захиалгат ажлаар дэмжин ажиллаж байна.
Урлаг, спорт дэмжих, тусламж	<ul style="list-style-type: none"> Жил бүр 30-аад тэрбум төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэн нийгмийн эмзэг бүлгийнхэнд тусалж, урлаг спортынхныг дэмжсээр ирсэн уламжлалтай.
Орон сууцны урьдчилгаа	<ul style="list-style-type: none"> Ажиллагсадаа орон сууцаар хангах бодлогын хүрээнд орон сууц худалдан авах ажилчдаа урьдчилгаа төлбөрийг хүүгүйгээр олгож эхлээд байна.

1. Япон дахь дадлага сургалтад хамрагдах зорилго

- Япон орон, Япон соёлтой танилцах
- Японы компани, үйлдвэрлэл, үйлчилгээний байгууллагуудын үйл ажиллагаатай танилцах
- Бизнесийн туршлага судлах, эргээд байгууллагадаа хэрэгжүүлэх
- Дунд шатны менежерүүдийг 5S сургалтад суулгах, агуулах, оффисын менежментийг сайжруулах
- UN-ий Хүний эрхийн зөвлөмжийг нөөцийн удирдлагын менежерүүдэд танилцуулах, хэлэлцүүлэг өрнүүлэх, компанийн дотоод журмын сайжруулалт хийх
- Ажлын байрны үр ашиг, аюулгүй байдал, цэвэр байдлыг сайжруулж, чанар, хариуцлагын соёлыг төлөвшүүлэх.
- SDGs /урам зоригтой үр бүтээлтэй ажиллах боломж - эрх тэгш цалин 2030/
- Япон хоол идэх, Япон хүнтэй танилцах.

2. Суралцсан зүйл

Sunaqua Toto LLC

- Ажиллах таатай орчин
- SDGs (урам зоригтой үр бүтээлтэй ажиллах боломж - эрх тэгш цалин 2030)
- Сайн бүтээгдэхүүнийг бүтээхийн өмнө сайн хүн бүтээх явдал нь ТОТО компанийн менежментийн гол философи юм. “Момоко Сабүро”

Toyota Kyushu Motors

- Чанар
 - Хүнд ээлтэй ажлын байрны орчин
 - Сургалт хөгжлийн хөтөлбөр
 - 1800 үзүүлэлт бүхий хяналт шалгалт
- Автоматжуулалт
- 2500 робот
 - Battery-ийн үйлдвэрлэлээ 100% автоматжуулах

Yaskawa electric

- Инновацын төвийн инновацилаг байдал
- Робот хүн хоорондын уялдаа холбоо

Star Flyer Co.,Ltd

- Шинэ санааны уралдаан

- Шинэчлэлтийг хурдан нэвтрүүлж бусад компаниудаас ялгарч чаддаг “Байгууллагын үзэл баримтлал нь ажилтнуудын зорилготой НЭГ байдаг. Нэгэнт зорилго нэг бол ажилтан бүх зүрх сэтгэлээ ажилдаа зориулж үйлчлүүлэгчийн зүрх сэтгэлд хүрнэ. “

Kokorozashi

- Урт наслах гэдэг нь тооноос гадна эрүүл идэвхтэй, аз жаргалтай амьдрахыг хэлнэ.
- Захирлын “топ” мессеж

Nakashima Tarret

- Үйлдвэрлэлийн салбарын үндэс болсон /5S, Кайзэн үйл ажиллагаа/
- Итгэл, тууштай байдал, тэвчээр шаардлагатай
- Тогтмол шалгах, дүгнэх хэрэгтэй
- Удирдлага өөрөө дуртай байх

ДҮГНЭЛТ:

- Нийтлэг нийгмийн сайн сайхны төлөө зорьдог
- Уламжлалт хэв маягаа сайн хадгалдаг /давуу болон сул тал байгаа/
- Автоматжуулалт
- Чанар, стандартыг нэн тэргүүнд тавьдаг
- SDGs хэрэгжүүлдэг

3. Сургалтаар суралцсан, байгууллагадаа хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө

- **SDGs**
 - Одоо ямар түвшинд байгааг анализ хийх
 - Үйл ажиллагаандаа тусгах төлөвлөгөө гаргах
- **Чанар, стандартын судалгаа хийх**
 - Бүтээгдэхүүн үйлчилгээний чанарын судалгаа хийх
 - Сайжруулах ажлын хэсэг томилох
 - Шаардлагатай ISO стандарт хэрэгжүүлэх
- **Японы байгууллагуудын нийтлэг соёлыг байгууллагадаа нэвтрүүлэх**
 - Мэндлэх, хүндлэх соёл
 - Байгууллагын зорилгоо ажилтан бүр ойлгодог байх
- **Төлөвлөгөөт ажлын гүйцэтгэлийн хяналтыг сайжруулах**
 - Цагийн юм цагтаа...
 - Зөв төлөвлөх, тогтмол хянах
- **Автоматжуулалт**
 - Ажлын байран дахь автоматжуулах боломжтой ажлын процессуудыг судлах
 - 2025 оны бизнес төлөвлөгөөнд тусгах

- Хэрэгжүүлэх
- **Бизнес ба хүний эрхийн зарчмуудтай танилцах**
 - НҮБ-ийн бизнес ба хүний эрхийн удирдах зарчмыг судлах
 - Монголын засгийн газрын боловсруулсан үйл ажиллагааны төлөвлөгөөтэй танилцах
 - Хүний эрхийн зарчмын шинжилгээ хийх

4. Цаашид хэрэгжүүлэхийг хүсэж буй үйл ажиллагааны агуулга (Компани болон хувь хүний хувьд)

- Гадаад болон дотоодын хэрэглэгч, худалдан авагч нарт бүтээгдэхүүнээ 100 % чанартай хугацаанд нь үйлдвэрлэн өгч чаддаг итгэлтэй, найдвартай компани мөн гэсэн үнэлэлттэй болох
- Хэрэглэгчийн сэтгэл ханамж, бүтээгдэхүүн үнэлгээний судалгаа, дүгнэлтийг үйлдвэрлэл, борлуулалтын төлөвлөлтөд зөв хэрэглэдэг болох
- Түүхий эд, бэлэн бүтээгдэхүүний үнийн бодлогод хятадын нөлөөнөөс гарах
- Бүх ажил үйлчилгээ, бизнес үйл ажиллагааны талаар судалгаа, шинжилгээний ажил, дүгнэлт саналыг байнга хийлгүүлж чухал шийдвэр гаргалтад хэрэглэдэг, байнга хэвшүүлэх
- Бүх ажилтан “БАГ”-аар ажиллах чадвар эзэмших
- Бусдаас өөрийн компанид болон АТ-нд хэрэгтэй, зөв гэж үзсэн менежмент, технологийг өөрийн ажил үйлчилгээнд нэвтрүүлэх ажлыг санаачилгаараа хийдэг болох, хэрэгжүүлж үр дүнг байнга дээшлүүлэх

5. Дараа дараагийн сургалтад хамрагдах хүмүүст зориулсан зөвлөгөө, анхааруулах зүйл

- Сургалтын дараа компанидаа тогтвортой ажиллах
- Олж авсан мэдлэг, ойлголт, туршлага, сайн үр дүнг хамт олондоо аль болох хүртээмжтэй өгөх, сургалт зохион байгуулах
- Тухайн сургалт, семинар, уулзалтын гол Зорилго нь юу байна, ямар мэдлэг, мэдээлэл өгөх гээд байна, үр дүн давуу тал нь юу байв гэдэг талаас нь маш идэвхтэй оролцож мэдлэг олж авах, олсон мэдлэгээ ажилдаа хэрэгжүүлэх, хэвшүүлэх
- Компанидаа хэрэгтэй шинэ санааг тухайн сургалтаас эрэлхийлж олж авах, санал шүүмжлэлдээ оруулж тайлагнах
- Ажлын байрны эмх цэгцтэй холбоотой 5S-ийн дүрмүүдийг байнга хэрэглэж хэвшүүлэх

Нэр:

Д.Долгормаа

Албан тушаал:

Гүйцэтгэх захирал



Компанийн нэр	Моншибасаки ХХК
Байгуулагдсан он	2005
Үйл ажиллагааны чиглэл	Автомашины жижиг эд анги үйлдвэрлэл, экспорт
Ажилчдын тоо	34

Компанийн товч танилцуулга

Моншибасаки ХХК нь Японы авто машин үйлдвэрлэлийн зах зээлд бүтээгдэхүүнээ нийлүүлдэг, үйлдвэрлэлийн аутсорсинг хийх замаар Монгол Япон хоёр орны хөгжлийг холбож буй экспортлогч компани юм.

Манай компани суудлын болон ачааны автомашины тормос, жолооны хүрд, суудал, хөдөлгүүр мөн хурдны хайрцагт угсрагддаг жижиг эд анги болох нийт 72 нэр төрлийн бүтээгдэхүүнийг жилд дунджаар 2,5 сая ширхэгээр үйлдвэрлэж байна.



- ТӨЛӨВЛӨЛТ /P/ Захиалга авах
- ГҮЙЦЭТГЭЛ /D/ Бэлдэц хүлээн авах, үйлдвэрлэх
- ХЯНАЛТ /C/ Шалгах, савлах, илгээх
- САЙЖРУУЛАЛТ /A/

1. Япон дахь дадлага сургалтад хамрагдах зорилго

1. Монгол-Японы төвийн Үндэсний сургагч багшийн хувиар аливаа сургалтыг хэрхэн үр бүтээлтэй явуулж болох талаар туршлага судлах, өөрийгөө хөгжүүлэх, бусдаас суралцах зорилготой байсан.
2. Ковидын дараах Япон улсын үйлдвэрлэл, бизнес эрхлэлтийн менежментэд ямар өөрчлөлт орсныг харьцуулан харах, суралцан танин мэдэх хүсэлтэй байсан.
3. Олон улсын шинжтэй эдийн засгийн томоохон өөрчлөлтүүдээс үүдэх автомашины үйлдвэрлэл буурах, иений ханш унах зэрэг бэрхшээлийг хэрхэн зөв оновчтой даван туулж, үйл ажиллагаагаа хэвийн, тогтвортой хадгалан үргэлжлүүлж байгааг ойлгох, компанид маань учраад буй бодит хүндрэл, тулгамдсан асуудлаа шийдэхэд тус дэм болохуйц туршлага мэдлэг судлахыг хүссэн.

2. Суралцсан зүйл

1. Аливаа сургалтыг удирдан явуулахдаа “би энэ хүмүүст хэрэгтэй мэдлэг мэдээлэл өгч байна” гэдэг хэт өрөөсгөл ойлголт, хэт хатуу үүрэг хариуцлагаар хандаж, мэдээллээр бөмбөгдөх биш харин “хамтдаа хөгжих гэж байгаа учраас харилцан ярилцаж, сургалтад сууж буй хүмүүсийн оролцоог хангаж, тэдний санаа бодлыг сонсох замаар идэвхжүүлж, мэтгэлцэх, сэтгэх боломж олгож, асуудлын шийдлийг өөрсдөөр нь олуулах” зөв, зөөлөн ур чадварт суурилж ажиллах ёстойгоо ойлгож авсан. Дүүргэх ёстой сав шиг харах биш, асаах учиртай бамбар гэдэгт итгэ хэмээх үг нь дан ганцхан ерөнхий боловсролын сургуулийн багш нарт зориулсан үг биш, томчуудад ч зориулагдсан гэдгийг үргэлж бодож явах болно. Энэ нь Монгол-Японы төвийн Үндэсний сургагч багш хэмээх хүндэтгэлт нэрийг сонсох болсон миний хувьд маш том олз байлаа.
2. Танилцсан газрууд, туршлага судалсан үйлдвэр компаниудаасаа олж харсан хамгийн чухал мэдлэг, мэдээллүүдийг хамт олонтойгоо үе шаттайгаар хуваалцаж байна.
Тэр тусмаа ажиллах хүчний багагүй хувийг эзлэх болсон Y болон Z үеийнхний онцлог, тэдэнтэй харилцах харилцааны болон шинэ үеийнхний соёлын талаар сонсож мэдсэн мэдлэг мэдээллээ ажлын орчин, харилцааны арга барилдаа тусган шингээхийг зорьж байна.

3. Япон дахь дадлага сургалтаар сурсан зүйл

1. Бусдаас суралцахад суралцлаа.
2. “Үнэ, чанар, нийлүүлэлт” гэсэн суурь хүчин зүйлсээс гадна “үнэ цэн”-ийг бүтээж буй талаар суралцлаа. Өөрийн компанийн философид энэхүү хандлага сэтгэлгээг нэвтрүүлнэ.

4. Сургалтын үр дүн, сэтгэгдэл


1. Энэ удаагийн сургалт удирдлага зохион байгуулалт сайтай, сургалтад хамрагдах хугацааны баримтлах зарчим тодорхой, явах маршрут ойлгомжтой, очсон үзсэн танилцсан газар бүр шинэ содон, ухаарал сэхээрэл төрөхүйц, хийж бүтээх урам сэдэл авахуйц байж чадлаа. Тэр тусмаа “хүний эрхийн нэг чухал ойлголт бол оролцоог хангах явдал” гэдгийг бат нот ойлгуулж өгсөн Ямада Мива багш, “сургалт бол хамтран сэтгэх сэтгэлгээний нэгдэл, суралцагчдаа сэтгэх боломж олгох, мэдлэг ойлголт, сэтгэл сэтгэлгээг нь задлан сайжруулах, хөгжих замаа олоход нь дэмнэх мөн чанарын загварчлал” болохыг батлан харуулсан Гото багш, Мүрата багш гээд уулзсан хүн бүр эрдэм мэдлэгтэй ч эгэл даруухан, энгийн атлаа эрхэмсэг байсныг хэлэхэд сайхан байна. Мөн нэг баг болон сургалтад хамт явсан залуус, сургагч багш нар, бизнес эрхлэгчдийн маань хандлага харилцаа гайхам эерэг, сэтгэл сэтгэлгээ, мэдлэг боловсролоос нь суралцмаар баялаг, хүмүүжил ёс суртахууныг нь хүндлэм байсныг хэлэхэд таатай байна.
Ер хүний сайнтай хамтарч, харилцан суралцсан, бахархах зүйл ихтэй сайхан сургалт болж өнгөрсөн.
2. Кита Кюүшү хотын ээжүүд эмэгтэйчүүд манлайлан хотынхоо агаар, ус хөрсний бохирдолтой хэрхэн яаж бүтээлчээр тэмцэж, үр хүүхдүүдээ хамгаалж чадсан тухай түүхийг үзэж, сонсож явахдаа Улаанбаатарын иргэн бидэнд тэднээс суралцах зүйл маш их байгааг харьцуулан бодож явсан. Мөн энэ хотын нэрийн хуудас болсон Sunaqua Toto компанийн нийт ажилчдын 86,99% нь хөгжлийн бэрхшээлтэй иргэд байдаг нь жинхэнэ “түгээмэл хөгжлийг дэмжигч, хүний эрхийг дээдлэгч”-ийн үлгэр жишээг үзүүлсэн. Тэндээс гарахдаа би “хүн ямар асуудал бэрхшээлтэй байхаас үл хамааран өөрт таарсан зүйлээ хийж түүнээсээ аз жаргал мэдэрч амьдрах эрхтэй” гэдэг ухаарал тээсээр буцсан.
Цааш 10,600 ажилчинтай Toyota компанитай танилцах үеэрээ “орон зайн хэмнэлт”-ийг бодитойгоор харж гайхширсан бол өөр компани дээр очоод роботтой зэрэгцэн ажиллах хүмүүсийн нүдийг хараад “хүн робот хоёрын адил төстэй хийгээд ялгаатай тал”-ын тухай өөрийн эрхгүй эргэцүүлэхэд хүрч, хүний сэтгэлийг чухлын эрэмбийнхээ нэгдүгээрт тавин ажилладаг агаарын тээврийн компанийн үйлчилгээний зорилгын алсын хараатайг бахадсан, Монгол Улс Кита Кюүшү хотын туршлагаас суралцаж, “сэргээгдэх эрчим хүчний парк”-тай болж болох нь байна... гээд Фүкүока мужаас авч үлдсэн, цаашид хэрэгжүүлэх олон зүйлийн олзтой буцсан.
3. Гэрэлт хот Нагасакид жил бүр таван тивийн хүмүүс цуглаж, энх тайвныг эрхэмлэх ёслолд оролцдог бөгөөд “атомын бөмбөгийн аюул”-ыг хүн төрөлхтөнд сануулан сэрэмжлүүлсээр ирсэн газар. Нагасакид дэлхийн олон улс орны хүндэтгэл харууслын хийгээд нөхөрлөлийн хөшөө боссон юм билээ. Удахгүй Монгол Улсыг илэрхийлэх дурсгал бий болох байх гэж найдаж байна.
Нагасаки мужийн Kouin буюу аз жаргалыг тээвэрлэгч гэдэг нэртэй орон нутгийн тээврийн компани “итгэл аюулгүй байдал” хоёрыг эрхэмлэж, 5S, чанарын удирдлагын тогтолцоог ягштал баримтлан ажиллаж буйтай танилцан, үйлчилгээний Япон соёлын стандартын мэдээллээр мэдлэгээ зузаалсан.

5. Дараа жилийн сургалтад хамрагдах хүмүүст зориулсан зөвлөгөө

Ёс суртахуун, зарчим, хүндэтгэл гурваар хүлэг унаа хийж, бусдаас суралцах боломжоо сайн ашиглаарай. Олон зүйлд сатаарч бус гол зорилгодоо төвлөрөөрэй.

Нэр:

О.Баярмаа



Ажиллаж буй байгууллагын нэр	Монгол-Японы хүний нөөцийн хөгжлийн төв
Албан тушаал	Бизнесийн сургалтын тасгийн ахлах мэргэжилтэн
Байгуулагдсан он	2002 он
Үйл ажиллагааны чиглэл	Боловсрол, соёлын үйл ажиллагаа
Нийт ажилтны тоо	31

Компанийн товч танилцуулга

Монгол-Японы хүний нөөцийн хөгжлийн төв нь Монголын зах зээлийн эдийн засагт хувь нэмэр оруулахуйц хүний нөөцийг хөгжүүлэх Монгол, Япон хоёр орны харилцаа, хамтын ажиллагааг бэхжүүлэх зорилгоор Японы Олон Улсын Хамтын Ажиллагааны Байгууллага (ЖАЙКА), Боловсрол, Соёл, Шинжлэх ухааны яам болон МУИС-н хамтарсан төсөл хэлбэрээр 2002 оноос үйл ажиллагаагаа



эхлүүлэн өдгөө 22 дахь жилдээ үйл ажиллагаагаа тогтмол явуулж байна. Бизнесийн хүний нөөцийг хөгжүүлэх сургалт, япон хэлний боловсрол, соёлын үйл ажиллагаа, 2 орны бизнесийн хамтын ажиллагаа гэсэн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байна. Мөн өнөөг хүртэл бий болгосон харилцаа холбоогоо үр дүнтэйгээр ашиглан Япон, Монголын бизнесийн гүүр болон ажиллахыг зорьж байна.

1. Япон дахь дадлага сургалтад хамрагдах зорилго

Миний бие цаашид сургалтын үйл ажиллагааг зохион явуулах төдийгүй сургагч багш болохоор дадлага, туршлага хуримтлуулж байна. Тиймээс энэ удаагийн Япон дахь дадлага сургалтад дараах зорилго тавин хамрагдлаа.

- Сургагч багшийн байр сууринаас Японы компаниудын менежментийн арга

барил, туршлагаас суралцах


- Японы компаниудын хүний нөөцийн бодлого, хүний нөөцийн менежментийн чиг хандлага, ажилтнаа сургаж хөгжүүлэх арга барил
- Сургалтад хамрагдаж буй Монгол компанийн захирал, менежерүүдийн сургалтад оролцож буй байдал, асуулт, сонирхож буй сэдвийг таньж мэдэх, цаашид сургагч багшаар ажиллах сэтгэл зүйн бэлтгэл, сургалтын арга барил, оролцоонд тулгуурласан сургалтын талаарх мэдлэг, туршлагаас суралцах

2. Суралцсан зүйл

Энэ удаагийн дадлага сургалтаар бид Кита Кюүшү хот болон Нагасаки мужийн нийт 14 компани, аж ахуйн нэгжтэй танилцлаа. Үүнээс гадна багш нарын сургалтын хүрээнд Relo Excel ХК-ийн олон улсын сургалтын хүрээлэнгийн багш Мүрата Тошияа багшийн семинарт хамрагдаж, насанд хүрэгчдэд зориулсан сургалтын арга барил хийгээд багшийн анхаарах болон анзаарах зүйлсийн талаар санал бодлоо солилцсон юм.

Хувийн хэвшлийн байгууллагаар зочлохдоо анзаарсан зүйлс:

- Тогтвортой хөгжлийн талаар компани төдийгүй хувь хүний ойлголт маш өндөр байна. Энэ нь Япон улсад аливаа шинэ санал санаачилга, дүрэм журмын талаар сурталчилгаа маш сайн хийгддэгтэй холбоотой болов уу. Компани нь бүтээгдэхүүн үйлдвэрлэхдээ зөвхөн үйлдвэрлээд хэрэглэгчдэд хүргээд дуусах бус, үйлдвэрлэх явцад үүссэн болон хэрэглэгчид хэрэглэсний дараа гарах хог хаягдлыг хэрхэхээ хүртэл бодолцож бүтээгдэхүүн үйлдвэрлэлээ явуулж байна.




- Аливаа компанийн үүсгэн байгуулагчийн философи маш чухал үүрэгтэй тод томруунаар харж чадлаа. Олон жил оршин тогтнож байгаа компанид өөрчлөх ёстой болон өөрчлөх ёсгүй зүйл байж, өөрчлөх ёсгүй зүйлийн эхэнд нь



компанийн философи нэрлэгдэж байлаа. Тухайн компанийг юуны тулд, ямар итгэл үнэмшлийн тулд бий болгосон нь удаан оршин тогтнох нэг үндэс нь болж байна уу гэж харагдлаа. Үүнийгээ зөвхөн дотроо хадгалах бус, үүсгэн байгуулагч, түүний дараа дараагийн үе залгамжлагч нар

тухайн философийг залгамжлан, түүнийгээ ажилтнууддаа болон хэрэглэгчдэдээ түүх болгон өгүүлэх нь чухал болохыг мэдэрлээ.

- Хамтын ажиллагаа буюу төр, хувийн хэвшил, ард иргэдийн хамтын ажиллагаа маш сайн байгаа буюу хойч үеэ бодолцон дор бүрнээ хариуцлагатай хандаж байна.



- Data мэдээлэлд дүн шинжилгээ хийж, түүнд тулгуурлан аюулаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг эртнээс авах, мэдээллийг ил тод түгээх. Цагийг нь тулгаж арга хэмжээ авах бус маш эртнээс бэлтгэлтэй байгаа нь суралцах зүйл байлаа.

Багш нарт зориулсан сургалтаас анзаарсан зүйл:

- Суралцагч бүр өөр, мөн хичээл удирдах багш ч мөн адил тусдаа хувь хүн гэдгийг ухамсарлах буюу хувь хүн бүрийн ялгаатай байдлыг ойлгож, хүлээн зөвшөөрөн сургалтаа явуулах – High context, low context
- Цаг үетэйгээ уялдсан менежментийн арга барил буюу тухайн цаг үеийн хөгжлийн түвшинтэй уялдан менежментийн арга барил өөр байхыг анзаарах
- Суралцагчдад зөвхөн нэг өнцгөөс заах бус бие даан бодох чадвар суулгах сургалтын арга барил
- Суралцагчдын сэтгэл зүйн аюулгүй байдлыг хангах - Psychological safety
- Багшийн facilitation skill-с суралцлаа.

3. Сургалтаар суралцсан, байгууллагадаа хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө

Дараах зүйлсийг хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.

- Дотоод мэдээлэл дамжуулах процессыг ил тод нээлттэй болгох
- Ажилтнуудын ажиллах орчныг үнэлэх, 5S патролыг илүү бодит үр дүнтэй болгох
- Сургалтын арга барилыг илүү суралцагчдын оролцоотой болоход анхаарах
- Одоо явагдаж байгаа сургалтын агуулга болон төрлийг нэмэгдүүлэх. Ялангуяа бизнесийн нээлттэй семинарыг олон нийтэд хандан олон тоогоор явуулах
- Нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд МЯТ-ийн хувьд төгсөгчдөө холбон ажиллах гүүр болох боломжийг эрэлхийлэх

4. Цаашид хэрэгжүүлэхийг хүсэж буй үйл ажиллагааны агуулга (Компани болон хувь хүний хувьд)

Хувь хүний хувьд дараах зүйлд анхаарлаа хандуулан ажиллахаар зорьж байна.

- Хийх зүйлээ төлөвлөх, мөн хийхгүй зүйлээ шийдэх. Олон зүйлд сатаарах, өөрийн сонирхолгүй болон чадахгүй зүйлийг хийж гүйцэлдүүлэх гэж хичээснээр цаг хугацаа, энерги тарамдах тул гол зүйлдээ төвлөрөх нь чухал.
- Багаар хийж эхлээд томсгох. Аливаа зүйл эхнээсээ төгс байх албагүй ба өөрийн хийж чадах хэмжээнд эхлүүлээд бага багаар түүнийгээ сайжруулах замаар хамгийн сайн хувилбарыг бий болгоно. Японоор Кайзэн гэдэг үг өдгөө Монголд орчуулгагүй хэрэглэгддэг болсон билээ.


5. Дараа дараагийн сургалтад хамрагдах хүмүүст зориулсан зөвлөгөө, анхааруулах зүйл

Сургалтад хамрагдахаас өмнө чиглүүлэх сургалт дээр олноор анхааруулдаг ч яг бодитоор сургалтаа эхлэхээс нааш толгойд буудаггүй хэдэн зүйл байна.

- Урьдчилаад зочлох компанийн талаар мэдээлэл өгдөг учраас уншиж танилцаад, би эндээс юу ажиглах вэ гэдгээ шийдвэл амар болов уу
- Асуулт асуухдаа зөвхөн өөрийн болон өөрийн компанид тулгарч буй асуудлын талаар гэхээсээ илүү анги нийтэд хэрэгтэй асуулт асуувал бүгд хамтдаа суралцана
- Нэг хүний л эерэг хандлага бүх хүнд шууд нөлөөлдөг тул бусадтайгаа сайхан харилцаж, хамтдаа сурах, хамтдаа өсөж хөгжих юм шүү гэдэг сэтгэлээр хандаарай.

Нэр:

Х.Жаргалмаа



Ажиллаж буй байгууллагын нэр	Монгол-Японы хүний нөөцийн хөгжлийн төв
Албан тушаал	Бизнесийн сургалтын тасгийн мэргэжилтэн
Байгуулагдсан он	2002
Үйл ажиллагааны чиглэл	Боловсролын үйл ажиллагаа
Нийт ажилтны тоо	31
Компанийн товч танилцуулга	
<p>Монгол-Японы хүний нөөцийн хөгжлийн төв нь Монголын зах зээлийн эдийн засагт хувь нэмэр оруулахуйц хүний нөөцийг хөгжүүлэх Монгол, Япон хоёр орны харилцаа, хамтын ажиллагааг бэхжүүлэх зорилгоор Японы Олон Улсын Хамтын Ажиллагааны Байгууллага (ЖАЙКА), Боловсрол, Соёл, Шинжлэх ухааны яам болон МУИС-н хамтарсан төсөл хэлбэрээр 2002 оноос үйл ажиллагаагаа эхлүүлсэн. Одоо бизнесийн хүний нөөцийг хөгжүүлэх, япон хэлний боловсрол, хамтын ажиллагаа гэсэн үндсэн үйл ажиллагаа явуулж байна. 2012 оноос япон хэлний боловсрол болоод хоёр орны хамтын ажиллагааны хувьд Япон сантай хамтран ажиллаж байна. Мөн өнөөг хүртэл бий болгосон харилцаа холбоогоо үр дүнтэйгээр ашиглан Япон, Монголын бизнесийн гүүр болон ажиллахыг зорьж байна.</p>	
1. Япон дахь дадлага сургалтад хамрагдах зорилго	
<ul style="list-style-type: none">- Бизнесийн мэдлэгээ дээшлүүлэх- Байгууллагуудын маркетингаас суралцах- Залуу ажилчдын ажилдаа хандах хандлага болон байгууллагаас хүний нөөцөө хөгжүүлэхэд авч хэрэгжүүлж буй арга хэмжээнээс суралцах- Байгууллага болон сургалтын үйл ажиллагаа, хүртээмжийг сайжруулах шинэ санаа олж авах	

2. Суралцсан зүйл

1. Япон байгууллагуудын онцлог, олон жил оршин тогтнож байгаа нууц
2. Хүн нэг бүрийн оролцоо, үүрэг хариуцлагаа ухамсарлан бүгд нэгэн зүгт харж чадаж байгааг
3. Өнцөг булан бүрд Тогтвортой хөгжлийн зорилтыг ханган ажиллаж, байгууллагууд нь үйл ажиллагаандаа ямар нэгэн байдлаар тусгаж өгч, мөрдөн ажиллаж байгааг
4. Зөвхөн ашиг олох биш нийгмийн сайн сайхны төлөө мөн хичээж ажиллах ёстойг
5. Жижиг зүйлийг ч жижиг, ач холбогдол багатай гэж орхилгүй анхаарч байх ёстойг
6. Алдаагаа олж харах нь муу биш харин ч сайн зүйл бөгөөд тухай бүрд нь алдаагаа засаж, сайжруулж явснаар өндөр чанар гэдэг зүйл бий болдгийг
7. Ажилтнуудынхаа саналыг маш сайн сонсож, хэрэгжүүлж болохуйц санал санаачилга байвал тухай бүрд нь цаг алдалгүй шийдэж явах нь ямар их цаг хугацаа хэмнэдэг гэдгийг
8. 5S, Кайзэн үйл ажиллагааг удаан хугацаанд тасралтгүйгээр амжилттай хэрэгжүүлж байгааг сурч авлаа.

3. Сургалтаар суралцсан, байгууллагадаа хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө

- Ажилтнуудын ажил, амралтын хүснэгт гаргах (тухайн өдөр хэн амарч, хэн ажиллаж байгааг харж хянах боломжтой)
- SDG-ийн хүрээнд шинэ ажлууд санаачлан хэрэгжүүлэх (хандивын арга хэмжээ гэх мэт)
- 5S, Кайзэн үйл ажиллагааг тогтмол, үргэлжлүүлэх хэрэгжүүлж байх

4. Цаашид хэрэгжүүлэхийг хүсэж буй үйл ажиллагааны агуулга (Компани болон хувь хүний хувьд)

Байгууллагын хувьд:

- Сургалттай холбоотой цахим контент хийх
- Сургалтын хүртээмжийг сайжруулах зар сурталчилгааны шинэ хэлбэрийг оруулж ирэх
- Үндсэн сургалт төгсөгчдийн эргэх холбоог сайжруулах арга хэмжээг жил бүр тогтмол зохион байгуулах

Хувь хүний хувьд:

- Ажлын төлөвлөгөөг өдөр, 7 хоног, сараар гаргаж байх
- Шинэ сургалт, нээлттэй семинаруудыг санаачлах

5. Дараа дараагийн сургалтад хамрагдах хүмүүст зориулсан зөвлөгөө, анхааруулах зүйл

1. Цаг баримтлах
2. Өөрийн эд зүйлсдээ хянамгай хандах
3. Бусдад аль болох төвөг учруулахгүй байх
4. Монгол улсыг төлөөлж оролцож байгаагаа ямагт санаж байх
5. Сургалтын үеэр өөр зүйл хийлгүй сургалтдаа анхааралтай, идэвхтэй оролцох